



БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

## УРАН ЗОХИОЛ

АНХДУГААР ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021





БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААНЫ  
ЯАМ



THE WORLD BANK  
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ASIAN  
DEVELOPMENT  
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

# СУУРЬ, БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

## УРАН ЗОХИОЛ

*АНХДУГААР ХЭВЛЭЛ*

УЛААНБААТАР 2021





## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

|                               |    |
|-------------------------------|----|
| Эрх зүйн баримт бичгүүд ..... | 7  |
| Боловсролын үнэлгээ .....     | 17 |

## СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

### УРАН ЗОХИОЛ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. VI АНГИ

|                                                                    |    |
|--------------------------------------------------------------------|----|
| 1.1. VI ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн .....    | 22 |
| 1.2. Үнэлгээний нэгж .....                                         | 22 |
| 1.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж ойлгох.....               | 22 |
| 1.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....            | 22 |
| 1.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлгийг дуурайн зохиож, уран унших ..... | 24 |
| 1.2.4. Үнэлгээний нэгж 4. Бичих, ярих.....                         | 25 |

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ

|                                                                  |    |
|------------------------------------------------------------------|----|
| 2.1. VII ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн ..... | 26 |
| 2.2. Үнэлгээний нэгж .....                                       | 26 |
| 2.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж ойлгох.....             | 26 |
| 2.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....          | 27 |
| 2.2.3. Үнэлгээний нэгж 3. Мэдрэмж сэтгэгдлээ бичих .....         | 28 |
| 2.2.4. Үнэлгээний нэгж 4. Зохиолыг ярих .....                    | 29 |
| 2.2.5. Үнэлгээний нэгж 5. Бичих, ярих.....                       | 29 |

#### ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ

|                                                                   |    |
|-------------------------------------------------------------------|----|
| 3.1. VIII ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн ..... | 30 |
| 3.1. Үнэлгээний нэгж .....                                        | 30 |
| 3.1.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж ойлгох.....              | 30 |
| 3.1.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....           | 31 |
| 3.1.3. Үнэлгээний нэгж 3. Зохиолоос сэдэвлэн бичих .....          | 32 |
| 3.1.4. Үнэлгээний нэгж 4. Шүлэглэсэн зохиол .....                 | 33 |

#### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. IX АНГИ

|                                                                    |    |
|--------------------------------------------------------------------|----|
| 4.1. IX ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн .....    | 34 |
| 4.2. Үнэлгээний нэгж .....                                         | 34 |
| 4.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, агуулгыг ойлгох.....     | 34 |
| 4.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....            | 35 |
| 4.2.3. Үнэлгээний нэгж 3. Богино өгүүллэг бичих .....              | 36 |
| 4.2.4. Үнэлгээний нэгж 4. Санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх .....  | 37 |
| 4.2.5. Үнэлгээний нэгж 5. Уншсан зохиолоо танилцуулан илтгэх ..... | 38 |

## БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

### УРАН ЗОХИОЛ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. X АНГИ

|                                                                |    |
|----------------------------------------------------------------|----|
| 1.1. X ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн ..... | 42 |
| 1.2. Үнэлгээний нэгж .....                                     | 42 |
| 1.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, ойлгох.....          | 42 |
| 1.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....        | 43 |
| 1.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлэглэсэн зохиол .....              | 46 |

#### ХОЁРДУГААР БҮЛЭГ. XI АНГИ

|                                                                |    |
|----------------------------------------------------------------|----|
| 2.1. XI ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн..... | 47 |
| 2.2. Үнэлгээний нэгж .....                                     | 47 |
| 2.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, ойлгох.....          | 47 |
| 2.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....        | 48 |
| 2.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлэглэсэн зохиол .....              | 51 |

#### ГУРАВДУГААР БҮЛЭГ. XII АНГИ

|                                                                  |    |
|------------------------------------------------------------------|----|
| 3.1. XII ангийн уран зохиолын хичээлийн суралцахуйн үр дүн ..... | 52 |
| 3.2. Үнэлгээний нэгж .....                                       | 52 |
| 3.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, ойлгох.....            | 52 |
| 3.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх .....          | 53 |
| 3.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлэглэсэн зохиол .....                | 56 |





# МЭНДЧИЛГЭЭ

**Эрхэм баян-эрдэм мэдлэгийг түгээн  
дэлгэрүүлэгч эрдэмтэн багш нар аа!**

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй өнөөгийн нийгэмд зохицон амьдрах хувь хүний эрэлтийг нийгмийн хэрэгцээтэй уялдуулан хөгжүүлэхэд дэлхийн улс орнууд ихээхэн анхаарч, боловсролын тогтолцоогоо улам бүр боловсронгуй болгож байна.

Сургалтын хөтөлбөрт суралцагчийн суралцах чадварын хөгжил, шинжлэх ухааны мэдлэг, ойлголтын эзэмшилт, аливаа зүйлийг судлах сонирхол, идэвх зүтгэлд гарч буй ахиц амжилтыг үнэлэхээр үнэлгээний зорилтыг тодорхойлсон бөгөөд суралцагчийн үнэлгээний журамд “үнэлгээ нь шалгуурт суурилсан” байхаар заасан.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны “Шалгуур үзүүлэлт батлах тухай” А/180 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургуулийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд нийцүүлэн боловсруулж, баталлаа.

Энэхүү шалгуур үзүүлэлт батлагдсанаар суралцагчийн ахиц амжилтыг ижил шалгуураар үнэлэх /суралцагчдын ялгаатай байдлыг тодорхойлох/, хичээлийн бэлтгэлийг чанартай хангах /нэгж, ээлжит хичээлийн төлөвлөлт хийх/ зэрэг багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчийн хамтын ажиллагааг сайжруулах, эргэх холбоотой ажиллах боломж бүрдэх юм.

Оюунлаг, чадварлаг, бүтээлч шинэ эриний “Монгол хүн” бүтээх гол цөм, тулах цэг нь болсон багш, боловсролын ажилтан та бүхэнд эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүсэн ерөөе.

Энэхүү гарын авлагыг боловсруулахад оролцсон эрдэмтэн багш, судлаач нар болон техникийн дэмжлэг үзүүлсэн Азийн Хөгжлийн банкны “Эдийн засгийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”, Дэлхийн банкны “Бага боловсролын шинэчлэл” төслийн хамт олонд талархал илэрхийлье.

## БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

Лувсанцэрэнгийн ЭНХ-АМГАЛАН  
Боловсрол, шинжлэх ухааны сайд





# МЭНДЧИЛГЭЭ

***Боловсролын үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох үйлсэд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулан ажиллаж байгаа эрдэмтэн багш, боловсролын ажилтан, судлаачид та бүхнийхээ энэ өдрийн амар амгаланг айлтгая.***

Суралцагчдад хаана, ямар орчинд суралцаж байгаагаас үл хамааран ижил шалгуур, ижил арга, аргачлалаар сурлагын амжилт, ахицаа бодитой тодорхойлуулах хэрэгцээ ямагт байдаг. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг бодитой, шинжлэх ухаанчаар үнэлж дүгнэн үнэлгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд үр нөлөөтэйгээр хэрэглэх нь манай орны төдийгүй дэлхийн улс орнуудын багш нарт ч сорилт хэвээр байна.

2018 онд БСШУС-ын (хуучнаар) сайдын А/425 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-д суралцагчийн үнэлгээг шалгуурт суурилсан бөгөөд суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сурлагын ахиц, амжилтыг дэмжиж, тэднийг хөгжүүлэхэд чиглэсэн байхаар тодорхойлсон нь дээрх хэрэгцээ, шаардлагыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Үнэлгээний шалгуур нь хичээл, сургалтын үр дүнд суралцагчийн юу мэддэг, юу чаддаг, яаж хийж хэрэглэх ёстойг тодорхойлж өгсөн суралцахуй, багшлахуйн ач холбогдолтой “үнэлгээний гол хэрэгсэл” юм. Багш та үнэлгээний шалгуурыг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэснээр суралцагчийн гүйцэтгэлд тулгуурлан сурлагын амжилт, ахиц, өөрчлөлтийн талаар бодитой, үр нөлөөтэй үнэлэлт, дүгнэлт хийж тэдэнд ямар дэмжлэг, хэрхэн үзүүлэхээ тодорхойлох бүрэн боломж бүрдэнэ.

Боловсролын үнэлгээний төв нь хичээл тус бүрээр эрдэмтэн, багш, судлаачдын баг бүрдүүлэн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр үнэлгээний нэгжийн түвшинд анх удаагаа боловсруулж та бүхний гар дээр хүргэж байна.

Үнэлгээний шалгуурыг олон улсын түвшинд боловсролын үнэлгээ, тэр дундаа суралцагчийн үнэлгээ, үнэлгээний шалгуур чиглэлээр баримталж буй онол, үзэл баримтлалд тулгуурлан өөрийн орны сургалтын хөтөлбөр, багшлахуй, суралцахуйн онцлогийг харгалзан боловсруулсан.

Боловсролын үнэлгээний тогтолцоог сайжруулахад үнэтэй хувь нэмэр оруулах эрхэм багш та бүхний үйлс нь улам өөдөө байж, боловсролын хөгжлийн төлөө сэтгэл, зүтгэл нэгдэн урагшилна гэдэгт итгэл дүүрэн байгаагаа илэрхийлье.

**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

**Лхагвасүрэнгийн ГАНБАТ**  
Захирал



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,  
СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ТУШААЛ



Захиргааны хэм хэмжээний  
актын улсын нэгдсэн санд  
~~2018~~ оны ~~02~~ сарын ~~23~~-ны  
өдрийн ~~3967~~ дугаарт бүртгэв.

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 29 өдөр

Дугаар А/425

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3 дугаар бүлгийн 3.2.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам”-ыг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн өмчийн бүх хэлбэрийн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад мөрдсүгэй.

3. Энэхүү журмыг албан бус сургалтын дүйцсэн хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчдыг үнэлэхэд баримталсугай.

4. Энэхүү тушаалаар батлагдсан журмын хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газар /Г.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/, нийслэлийн Боловсролын газар, аймгуудын Боловсрол, соёл, урлагийн газарт тус тус даалгасугай.

5. Журмыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг жил бүр улсын төсөвт тусгаж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Х.Галсанхүү/, Боловсролын үнэлгээний төв /Ж.Ган-Эрдэнэ/-д тус тус үүрэг болгосугай.

6. Журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны “Журам, загвар шинэчлэн батлах тухай” А/309 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон чанарын үнэлгээний журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД




Ц.ЦОГЗОЛМАА

0001553

# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын  
2018 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн  
А/425 дугаар тушаалын хавсралт



## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧИЙН БОЛОН СУРГАЛТЫН ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн мэдлэг, чадварын ахиц амжилт, үр дүн, төлөвшлийг үнэлж, дүгнэх, хөндлөнгийн хяналт, чанарын үнэлгээ хийхэд энэхүү журмыг баримтална.

1.2. Суралцагчийн үнэлгээ нь сурлагын ахиц, амжилтыг үнэлж, сургалтын арга хэлбэр, зохион байгуулалтад тохируулга хийх; анги дэвших болон сургууль төгсөх шалгалт /цаашид "улсын шалгалт" гэх/ нь сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнг үнэлж, сургуулийн үйл ажиллагаа, багшийн арга зүй, ур чадварыг сайжруулах; чанарын үнэлгээ нь боловсролын чанар, үр дүнг тодорхойлж, бодлого, төлөвлөлтийг боловсронгуй болгоход тус тус чиглэнэ.

### Хоёр. Үнэлгээнд баримтлах зарчим

2.1. Үнэлгээ нь шударга, бодитой, хөндлөнгийн нөлөөллөөс ангид, шалгуурт суурилсан, суралцагчийн сурах хүсэл эрмэлзэл, сонирхол, ур чадвар, ахиц, амжилтыг дэмжсэн, урамшуулах, хөгжүүлэхэд чиглэсэн байх;

2.2. Үнэлж дүгнэх үйл ажиллагаа нь зорилготой, сургалтын хөтөлбөрт нийцсэн, суралцагчийн нас, сэтгэхүй, хөгжлийн ялгаатай байдал, онцлог хэрэгцээг харгалзсан, агуулга, хэлбэр нь уян хатан, багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагчид ойлгомжтой, нээлттэй, ил тод байх;

2.3. Анги дэвших болон улсын шалгалтын сэдэв, даалгавар нь танин мэдэхүйн түвшинд нийцсэн, тохирц, найдварыг шалгасан, нууцлалыг хадгалсан, шалгуулагчдыг хүндэтгэсэн, найдвартай байх.

### Гурав. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээ

3.1. Суралцагчийн үнэлгээ нь тэдний эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, төлөвшил, хандлагын өөрчлөлтийг тооцох, сургууль, багшийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх, сургалтын чанар, үр дүнг сайжруулахад чиглэнэ.

3.2. Суралцагчийн үнэлгээ нь оношлох, явцын, үр дүнгийн гэсэн төрөлтэй байх бөгөөд үнэлгээ нь шалгуурт суурилсан байна.

3.3. "Шалгуурт суурилсан үнэлгээ" нь суралцагчийн амжилтын түвшинг хүрэх үр дүнтэй харьцуулан үнэлэхэд чиглэнэ.

3.4. Хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсролын түвшин, анги, хичээл бүрээр боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулж, батална.

3.5. Оношлох үнэлгээ нь хичээлийн жилийн эхэнд эсвэл нэгж хичээл, бүлэг сэдэв эхлэхийн өмнө суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг тандах зорилгоор хийх үнэлгээ байна. Оношлох үнэлгээг ажиглалт, ярилцлага, хэлэлцүүлэг, асуулт, сорил, судалгаа гэх мэт хэлбэрээр хийнэ.



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.6. Явцын үнэлгээ нь суралцахуйг дэмжих, сайжруулах зорилгоор хичээл, сургалтын явцад тогтмол хийх үнэлгээ байна.

3.7. Явцын үнэлгээг хичээлийн явцад суралцагчийн суралцах үйлийг дэмжихэд чиглэсэн ажиглалт, асуулт, ярилцлага, хэлэлцүүлэг, бие даах ажил, рубрик, суралцагчийн өөрийн болон бусад суралцагчийн үнэлгээ гэх мэт арга, хэлбэрээр багш хийнэ. Явцын үнэлгээг сургалтын баримт бичиг /багшийн журнал/-т стандарт бус тэмдэглэгээгээр тэмдэглэж болно.

3.8. Үр дүнгийн үнэлгээг сурлагын амжилтын үр дүнг хэмжих зорилгоор бүлэг сэдвийн төгсгөл болон хагас жил /II улирлын төгсгөл/, хичээлийн жилийн эцэс /IV улирлын төгсгөл/-т хийнэ. Анги дэвших, улсын шалгалт нь үр дүнгийн үнэлгээ байна.

3.9. Үр дүнгийн үнэлгээг аман болон бичгийн шалгалт, сорил, туршилт, судалгааны ажил, тайлан, төсөлт ажил, илтгэл, эссэ, бүтээл, биечлэн хийж гүйцэтгэх зэрэг хэлбэрээр хийнэ.

3.10. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн ахиц амжилт, өөрчлөлтийг үнэлэхэд I, II ангид оношлох болон явцын үнэлгээ, III-XII ангид оношлох, явцын, үр дүнгийн үнэлгээний төрлийг ашиглана.

3.11. Үр дүнгийн үнэлгээ нь тухайн хичээл, судлагдахууны агуулгын хүрээнд дараах 8 түвшинтэй байна.

| Түвшин | Үнэлгээ, хувиар | Үнэлгээний түвшний шалгуур                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|--------|-----------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| VIII   | 90-100          | <ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, хууль зарчим, зүй тогтлыг бүрэн ойлгож, шинжлэх ухааны үг хэллэг ашиглан аливаа асуудлыг тайлбарлах, тодорхойлох, үнэлэлт дүгнэлт өгөх, санал гаргах түвшинд эзэмшсэн</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах ямар ч нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгон хэрэглэдэг</li> <li>Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ шинжлэх ухааны үүднээс оновчтой илэрхийлдэг</li> </ul> |
| VII    | 80-89           | <ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль, зүй тогтол, хоорондын хамаарлыг ойлгож эзэмшсэн</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил бус нарийн төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлэн шинжлэн судлах үйлээ төлөвлөдөг</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах оновчтой аргыг сонгодог</li> <li>Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг, түүнийгээ оновчтой илэрхийлдэг</li> </ul>                                                                                                                                                               |
| VI     | 70-79           | <ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны юмс үзэгдэл, нэр томьёо, ухагдахуун, зарчим, хууль зүй тогтлыг ойлгосон</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил төвөгтэй нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах үйлийг зааврын дагуу төлөвлөдөг</li> <li>Асуудлыг шийдвэрлэх, мэдээллийг боловсруулах тохирох аргыг сонгон хэрэглэдэг</li> <li>Асуудал, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эргэцүүлэн бодож дүгнэлт гаргадаг</li> </ul>                                                                                                                                                                                                            |
| V      | 60-69           | <ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчим, хуулийг ойлгосон</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо шинэ нөхцөлд зааврын дагуу хэрэглэдэг</li> <li>Таамаглал /асуудал, асуулт/ дэвшүүлж, шинжлэн судлах, төлөвлөхөд оролцдог</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах тохирох аргыг сонгодог.</li> <li>Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, гол санааг илэрхийлдэг</li> </ul>                                                                                                                                                                                                                                                                 |
| IV     | 50-59           | <ul style="list-style-type: none"> <li>Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг бүрэн ойлгосон.</li> <li>Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил нөхцөлд хэрэглэдэг</li> <li>Асуулт асуух, асуудал таамаглал дэвшүүлж, шинжлэн судлах үйлд оролцдог.</li> <li>Асуудал шийдвэрлэх, мэдээлэл боловсруулах аргыг сонгон хэрэглэхийг хичээдэг.</li> <li>Асуудал, мэдээллийг эргэцүүлэн бодож, санал бодлоо энгийн байдлаар илэрхийлдэг</li> </ul>                                                                                                                                                                                                                                                    |



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

|     |       |                                                                                                                                                                                                                                                                                                                                     |
|-----|-------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| III | 40-49 | <ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахуун, зарчмыг ойлгох, тайлбарлах түвшинд эзэмшсэн</li> <li>• Эзэмшсэн мэдлэг ойлголтоо танил, хялбар нөхцөлд хэрэглэдэг</li> <li>• Бусдын дэмжлэгтэй, зааврын дагуу хялбар асуудлыг шийдвэрлэдэг</li> <li>• Асуулт асууж, таамаглал дэвшүүлдэг</li> </ul> |
| II  | 30-39 | <ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх, цээжлэх түвшинд эзэмшсэн</li> <li>• Эзэмшсэн мэдлэг ойлголтоо заавар, аргачлалын дагуу ашигладаг</li> </ul>                                                                                                                         |
| I   | 0-29  | <ul style="list-style-type: none"> <li>• Шинжлэх ухааны нэр томьёо, ухагдахууныг таних, нэрлэх түвшинд эзэмшсэн</li> </ul>                                                                                                                                                                                                          |

3.12. I-II ангид суралцагчийн тухайн хичээлийн жилд хүрсэн үр дүнг явцын үнэлгээнд үндэслэн анги удирдсан багш дүгнэн хувийн хэрэгт бичиж, эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.

3.13. III-XII ангийн суралцагчийг бүлэг сэдвийн төгсгөлд, хичээлийн жилийн II, IV улирлын эцэст тус тус багш үнэлнэ. Энэхүү үнэлгээний үр дүн /хувь/-г ангийн журналд тэмдэглэнэ. IV улирлын эцэст хийсэн үнэлгээ /хувь/ нь жилийн эцсийн дүн байна.

3.14. III-XII ангийн жилийн эцсийн дүн болон анги дэвших, улсын шалгалтын дүнг ангийн журнал, суралцагчийн хувийн хэрэгт анги удирдсан багш тус тус тэмдэглэнэ.

3.15. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийг тухайн төлөвлөгөө, хөтөлбөрт нийцсэн шалгуураар үнэлнэ. Шалгуурыг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын үнэлгээний байгууллага хамтран боловсруулна.

3.16. Хөгжлийн бэрхшээлийн онцлог, суралцах чадамжид суурилсан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн хөгжлийн ахиц, өөрчлөлтийг явцын үнэлгээгээр үнэлнэ. Суралцагчийн анги дэвших, сургууль төгсөх асуудлыг явцын үнэлгээнд үндэслэн, энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс шийдвэрлэнэ.

3.17. Ерөнхий боловсролын сургууль, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага багшид зөвлөн туслах зорилгоор суралцагчийн мэдлэг, чадварын түвшинд хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийж болно. Энэхүү үнэлгээ, хяналт-шинжилгээ нь тухайн байгууллагын жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан байна.

3.18. Суралцагчийн төлөвшилийг хичээл, хичээлээс гадуурх сургалтын ажилд оролцсон байдал, идэвх санаачилгын талаарх хичээл заадаг болон анги удирдсан багшийн тэмдэглэл, баримт нотолгоонд үндэслэн дараах чиглэлээр дүгнэж, суралцагчийн хувийн хэрэгт бичнэ.

- санал бодлоо илэрхийлэх, бусдыг хүндэтгэн харилцах, зөрчил, маргааныг эв зүйгээр шийдвэрлэх байдал;
- бие даан сурах арга барил, бусадтай хамтран ажиллах;
- шинжлэн судлах хүсэл эрмэлзэл, сонирхол, оролцоо;
- соёл, уламжлалаа дээдлэх, асуудал шийдвэрлэх чадвар, бүтээлч, ажил хэрэгч байдал;
- хувийн болон орчны эрүүл ахуй, аюулгүй амьдрах, байгальтай харьцах, хамгаалах, нийгмийн харилцаанд оролцох хандлагад гарч буй өөрчлөлт;
- шинэ орчин, харилцаанд дасан зохицох чадварт гарч буй өөрчлөлт.

3.19. Анги удирдсан багш суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийн үнэлгээний талаарх дүгнэлт, саналыг хичээлийн жилийн II, IV улирлын эцэст эцэг эх, асран хамгаалагчид танилцуулна.



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

3.20. Суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшлийн үнэлгээний мэдээлэл нууцлалтай байх бөгөөд энэхүү мэдээлэлтэй багш, суралцагч, эцэг эх, асран хамгаалагч цахим болон бусад хэлбэрээр танилцах боломжийг сургууль бүрдүүлнэ.

### Дөрөв. Анги дэвших шалгалт, түүний зохион байгуулалт

4.1. Анги дэвших шалгалт нь суралцагчийн мэдлэг, чадвар эзэмшилтийн түвшинг тогтооход чиглэнэ.

4.2. Сургууль нь энэхүү журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуурын дагуу дараах чиглэлээр журмын 3.9-д заасан хэлбэрээс сонгож анги дэвших шалгалтыг зохион байгуулна.

| Боловсролын түвшин   | Анги | Шалгалтын тоо | Шалгалтын чиглэл                                                                                                                                                                                                                               |
|----------------------|------|---------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Бага боловсрол       | III  | 1             | Нэгдмэл агуулга /III ангийн хөтөлбөрийн агуулгаар/                                                                                                                                                                                             |
|                      | IV   | 2             | <ul style="list-style-type: none"> <li>Сургууль сонгох 1 хичээл</li> <li>Нэгдмэл агуулга /шалгалттай хичээлээс бусад/</li> </ul>                                                                                                               |
| Суурь боловсрол      | VI   | 2             | <ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сургууль сонгох 1 хичээл</li> </ul>                                                                                        |
|                      | VII  | 3             | <ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сургууль сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/</li> </ul>                                                                 |
|                      | VIII | 3             | <ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Суралцагч сонгох 1 хичээл /шалгалтгүй хичээлээс/</li> </ul>                                                                |
| Бүрэн дунд боловсрол | X    | 3             | <ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Суралцагч сонгох 1 хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/</li> </ul> |
|                      | XI   | 3             | <ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/</li> <li>Математик</li> <li>Сонгох хичээл /хими, биологи, физик, газарзүй, нийгэм судлал, түүх, англи хэл, орос хэл хичээлээс/</li> </ul>              |

4.4. Журмын 3.4-т заасан байгууллагаас баталсан шалгуур болон “Анги дэвших шалгалтын бюпринт” /цаашид бюпринт гэх/, шалгалт зохион байгуулах нэгдсэн удирдамж, шалгалтын үр дүнд шинжилгээ хийх маягт, зөвлөмжийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага жил бүрийн 5 дугаар сарын 01-ний өдрийн дотор ерөнхий боловсролын сургуульд хүргүүлнэ.

4.5. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь ерөнхий боловсролын сургуулийн анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн “Даалгаврын нээлттэй сан” бүрдүүлж, өмчийн бүх хэлбэрийн сургуульд хүргэх, түүнийг хэрэглэх арга зүйгээр хангах ажлыг хичээлийн жилийн турш зохион байгуулна.

4.6. Анги дэвших болон улсын шалгалт зохион байгуулах ажлыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон “Шалгалтын комисс” зохион байгуулна. Комиссын дарга нь сургуулийн захирал байх бөгөөд сургалтын менежер, багш, суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөллийг оролцуулна. Комиссын гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл шалгалтын сэдэв, даалгавар боловсруулахад оролцохгүй.

## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

4.7. Энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

4.7.1. анги дэвших шалгалт зохион байгуулах удирдамж, дэг боловсруулж, хэрэгжүүлэх;

4.7.2. анги дэвших шалгалттай холбогдон гарсан аливаа гомдол, маргааныг эцэслэн шийдвэрлэх;

4.7.3. шалгалтын үнэлгээ, дүн мэдээг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагаас өгсөн зөвлөмж, маягтын дагуу нэгтгэн, шалгалт зохион байгуулж дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдамжаар хангах, хяналт тавих.

4.8. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын үр дүнд шинжилгээ хийж, сургууль бүрд зөвлөмж боловсруулж, жил бүрийн 8 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

4.9. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь анги дэвших шалгалтын дүнд үндэслэн зөвлөн туслах ажлын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлнэ.

4.10. Сургууль энэхүү журмын 4.8-д заасан зөвлөмжид үндэслэн сургалтын үйл ажиллагааг төлөвлөн явуулна.

### Тав. Улсын шалгалт, түүний зохион байгуулалт

5.1. Улсын шалгалт нь бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, сурлагын амжилтад хөндлөнгийн үнэлгээ, хяналт-шинжилгээ хийхэд чиглэнэ.

5.2. Улсын шалгалтын үр дүн нь бага, дунд боловсролын сургалтын үр ашиг тооцох, сурлагын амжилтыг сайжруулах суурь мэдээлэл болно.

5.3. Бага, суурь бүрэн дунд боловсролын түвшний төгсөх ангийн суралцагч дараах хичээлээр улсын шалгалт өгнө.

| Боловсролын түвшин   | Анги | Шалгалтын тоо | Шалгалтын агуулга                                                                                                                                                                                                                                                              |
|----------------------|------|---------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Бага боловсрол       | V    | 3             | 1. Монгол хэл<br>2. Математик<br>3. Хүн ба байгаль                                                                                                                                                                                                                             |
| Суурь Боловсрол      | IX   | 4             | 1. Монгол хэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/<br>2. Математик<br>3. Сонгох шалгалт: /суралцагч аль нэгийг сонгоно./<br>• Байгалийн ухааны нэгдмэл агуулга<br>• Нийгмийн ухаан, түүх /нэгдмэл агуулга/<br>4. Гадаадхэл /англи хэл, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/ |
| Бүрэн дунд боловсрол | XII  | 4             | 1. Монголхэл, бичиг, уран зохиол /нэгдмэл агуулга/<br>2. Математик<br>3. Сонгох шалгалт /хими, биологи, физик, газарзүй, нийгмийн ухаан, түүх аль нэгийг сонгоно/<br>4. Гадаад хэл /англи, орос хэл-аль нэгийг суралцагч сонгоно/                                              |

5.4. Улсын шалгалтын товыг боловсролын үнэлгээний байгууллагаас жил бүр тогтоох бөгөөд шалгалтыг улсын хэмжээнд зэрэг эхлүүлж, дуусгана.

5.5. Улсын шалгалтын үнэлгээг энэхүү журмын 3.11-д заасан үнэлгээгээр үнэлнэ.



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

5.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь "Улсын шалгалтын бюпринт" /цаашид бюпринт" гэх/, шалгалтын сэдэв боловсруулах, дүгнэх зөвлөмжийг жил бүрийн 5 дугаар сарын 15- ны өдрийн дотор баталгаажуулж, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад хүргүүлнэ.

5.8.Боловсролын үнэлгээний байгууллага нь бага, суурь, бүрэн дунд боловсролын анги бүрийн сургалтын хөтөлбөрт нийцсэн "Даалгаврын нээлттэй сан" /цаашид "даалгаврын сан" гэх/ бүрдүүлэх, шинэчлэх, баяжуулалт хийх ажлыг хариуцна.

5.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь "Улсын шалгалтын комисс"- ыг жил бүрийн 5 дугаар сарын 01 -ний өдрийн дотор байгуулна. Энэхүү комисс нь тухайн орон нутагт улсын шалгалт зохион байгуулах ажлыг удирдлага, арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллана.

5.10. Сургууль дээр улсын шалгалт зохион байгуулахтай холбогдуулан энэхүү журмын 4.6-д заасан шалгалтын комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

5.10.1.улсын шалгалтын удирдамж, дэгийг боловсруулж, шалгалтыг зохион байгуулах;

5.10.2.шалгалт эхлэхээс 1 өдрийн өмнө энэхүү журмын 5.7-д заасан бюпринт, зөвлөмжийн дагуу улсын шалгалтын сэдэв боловсруулж, нууцлалыг хариуцах;

5.10.3.шалгалтын дүн мэдээг боловсролын салбарын мэдээллийн системд оруулах ажлыг удирдан зохион байгуулж, хяналт тавих;

5.10.4.хөгжлийн бэрхшээлтэй суралцагч шалгалт өгөх тохиолдолд тэдний хөгжлийн онцлог, хэрэгцээнд тохирсон шалгалтын орчин бүрдүүлэх;

5.10.5.улсын шалгалттай холбогдон гарсан аливаа маргааныг эцэслэн шийдвэрлэх;

5.10.6.шалгалтын материал, тайланг сургуулийн архивт хүлээлгэн өгөх.

5.11.Шалгалт зохион байгуулах хугацаанд улсын болон олон улсын уралдаан, тэмцээнд оролцсон суралцагчийн улсын шалгалтын үнэлгээг нотлох баримтад үндэслэн жилийн эцсийн үнэлгээгээр тооцно.

5.12.Суралцагч өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох болон давагдашгүй хүчин зүйлийн улмаас шалгалт өгөөгүй эсвэл дутуу өгсөн тохиолдолд улсын шалгалтын үнэлгээг жилийн эцсийн үнэлгээгээр тооцож болно.

5.13.Боловсролын үнэлгээний байгууллага нь боловсролын салбарын мэдээллийн системд оруулсан улсын шалгалтын дүнд шинжилгээ хийж, жил бүрийн 10 дугаар сард багтаан, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад тус тус хүргүүлнэ.

5.14.Журмын 5.9-д заасан "Улсын шалгалтын комисс" нь улсын шалгалт зохион байгуулсан тайланг нэгтгэн, шалгалт дууссанаас хойш 10 хоногийн дотор боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Зургаа. Чанарын үнэлгээ, түүний зохион байгуулалт

6.1.Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ нь суралцагчийн мэдлэг, чадварын түвшинг үндэсний түвшинд тогтоох, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлийг судлах, боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэхэд чиглэнэ.

6.2.Чанарын үнэлгээг боловсролын үнэлгээний байгууллага зохион байгуулна.

6.3.Чанарын үнэлгээнд өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургуулийн нийт суралцагчийн 10-аас доошгүй хувийг хамруулна.

6.4.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээ зохион байгуулах товыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн тогтооно.

6.5.Чанарын үнэлгээг зохион байгуулах агуулгын хүрээ, шалгуурыг боловсролын үнэлгээний байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага хамтран жил бүрийн 01 дүгээр сард багтаан тогтооно.

6.6.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулах удирдамж, аргачлалыг жил бүрийн 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар баталгаажуулна.

## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН САЙДЫН А/425 ТООТ ЖУРМЫН ХАВСРАЛТ

6.7.Боловсролын үнэлгээний байгууллага нь чанарын үнэлгээний өгөгдлийн сан үүсгэх, дүн шинжилгээ хийж, тайлан, санал, дүгнэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага, боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллагад тус тус хүргүүлнэ.

6.8.Чанарын үнэлгээний үр дүнд үндэслэн энэхүү журмын 6.7-д заасан байгууллага бодлого боловсруулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулна.

6.9.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага чанарын үнэлгээний тайланд үндэслэн сурлагын амжилтыг сайжруулах төлөвлөгөө гаргаж ажиллана.

6.10.Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага нь чанарын үнэлгээг зохион байгуулахад бүх талын дэмжлэг үзүүлж ажиллана.

Долоо. Бусад

7.1.Аливаа төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадвар, төлөвшилийг үнэлэх, шалгалт зохион байгуулахыг хориглоно.

---oOo---



# МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН А/180 ТУШААЛ



## МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ТУШААЛ

2021 оны 05 сарын 14 өдөр

Дугаар А/180


Улаанбаатар хот

### Шалгуур үзүүлэлт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.8 дахь заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Журам шинэчлэн батлах тухай" А/425 дугаар тушаалаар батлагдсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон сургалтын чанарын үнэлгээний журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хавсралтаар баталсугай.
2. Суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг энэхүү тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур"-ыг баримтлан 2021-2022 оны хичээлийн жилээс эхлэн үнэлсүгэй.
3. Шалгуурын дагуу үнэлгээ хийх арга зүйн зөвлөмжийг боловсруулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтныг арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/, Боловсролын үнэлгээний төв /Л.Ганбат/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатарт даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

142110643

### **СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ** (*Student assessment*)

Сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, тэдэнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц;

### **ШАЛГУУР** (*Criteria*)

Зорилт, стандартын биелэлтийг тодорхойлоход ашигладаг жишиг үзүүлэлт эсвэл түвшин;  
(UNESCO-CEPES, 2007)

### **ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР** (*Assessment criteria*)

Суралцахуйн үр дүнд хүрэхэд шаардлагатай тодорхой мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлдог.

### **ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ** (*Diagnostic assessment*)

Хичээл, сургалтын эхэнд суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийг тандах зорилгоор хийгдэх үнэлгээ;

### **ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ** (*Formative assessment*)

Багш, суралцагчийн зүгээс суралцагчийн “суралцахуй”-г танин мэдэх, хариу үйлдэл үзүүлэх зорилгоор сургалтын явц /ээлжит хичээл/-д хийгдэх үнэлгээ;

### **ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭ** (*Summative assessment*)

Хичээл, сургалт /нэгж, хагас жил, жилийн эцэст г.м тодорхой хугацааны/-ын дараа үнэлгээний шалгуурт хүрсэн байдлыг тогтоож, цаашид суралцахуй болон багшлахуйд анхаарах зүйлийг тодорхойлох зорилгоор хийгдэх үнэлгээ;



### СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго<sup>1</sup>/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх<sup>2</sup>/, үнэлж дүгнэх<sup>3</sup> зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

### ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

1 Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

2 Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариултыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

3 Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад<sup>4</sup> нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



<sup>4</sup> Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс" судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.





## **СУУРЬ БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

### **УРАН ЗОХИОЛ**

*ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР*

Нэгдүгээр бүлэг - VI анги  
Хоёрдугаар бүлэг - VII анги  
Гуравдугаар бүлэг - VIII анги  
Дөрөвдүгээр бүлэг - IX анги



**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.VI АНГИ**

**1.1. VI АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН**

Сурагч уншсан зохиолоос соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд тусган хүлээж авах, задлан шинжлэх, дуурайн зохиох, үйл явдлыг нэмэн дэлгэрүүлж мэдрэмж сэтгэгдлээ бичих, зохиолыг сэтгэл татахаар ярих чадвар эзэмшинэ.

**1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ**

**1.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж ойлгох**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                        | Суралцахуйн үр дүн                                                                                                     |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 6.1а. Монгол аман яруу найргийн богино хэлбэрүүд домог, үлгэр, сургаалын яруу найраг, дэлхий дахины шилдэг үлгэр, өгүүллэгээс уншиж, соёлын хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээж авах | Сурагч уншсан зохиолоос ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна. |

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                                                                     | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                             |
|---|------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч уншсан зохиолоос ойлгосон, тусган хүлээж авсан зүйлээ соёлын хам сэдвийн хүрээнд илэрхийлж чаддаг болсон байна. | Сурагч уншсан зохиолын агуулгыг ойлгож, түүнээс тухайн үндэстний соёлын хам сэдвийн хүрээнд тусгаж авснаа амаар болон бичгээр илэрхийлдэг. |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                             | Гүйцэтгэлийн түвшин                                                                                                      |                                                                                                                                                                                 |                                                                                                                                                                                           |                                                                                                                                      |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                            | I                                                                                                                        | II                                                                                                                                                                              | III                                                                                                                                                                                       | IV                                                                                                                                   |
| Сурагч уншсан зохиолын агуулгыг ойлгож, түүнээс тухайн үндэстний соёлын хам сэдвийн хүрээнд тусгаж авснаа амаар болон бичгээр илэрхийлдэг. | Зохиолын агуулгаас ойлгосноо асуултын дагуу товч ярьдаг. Зохиолын агуулга ямар нийгэм, соёлтой холбогдож байгааг ярьдаг. | Зохиолын агуулгаар нь хувааж, хэсэг бүрд тохирсон нэр өгдөг. Зохиолд өгүүлэгдэж байгаа нийгэм, соёлтой холбогдох үг хэллэг, өгүүлбэрийг олж, утгыг таамаглаж, асууж тодруулдаг. | Зохиолын үйл явдлын уялдаа холбоог түлхүүр үг, бүдүүвчээр харуулдаг. Зохиолд үйл явдал нь тухайн нийгэм, соёлын хам сэдэвтэй холбон ойлгож, юуг мэдэрч, тусган хүлээж авснаа илэрхийлдэг. | Зохиолын сэдэв, гол санаа нь нийгэм, соёлын хам сэдэвтэй яаж холбогдож байгааг ойлгож, юуг мэдэрч, тусган хүлээж авснаа илэрхийлдэг. |

**1.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 | Суралцахуйн үр дүн                                                                                                                       |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 6.1б. Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (амьдчилал,адилтгал) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах<br>6.в. Зохиолын өгүүлэгдэхүүний үйл явдлын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллаар ялган таних<br>6.1.г. Зохиолын сэдэв, гол санааг тайлбарлах<br>•Зохиолын орчныг орон ба цагийн дүрслэлээр ялган таньдаг.<br>6.1.е. Зохиолын дүрийн үг, үйлдлээс зорилгыг тодорхойлох | Сурагч уншсан зохиолын бүтэц-агуулга, хэл-уран дүрслэл, сэдэв-гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг тодорхойлж чаддаг болсон байна. |



Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                                                                                        | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                   |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч уншсан зохиолын бүтэц- агуулга, хэл-уран дүрслэл, сэдэв-гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг тодорхойлж чаддаг болсон байна. | Сурагч зохиолын далд утгыг уран дүрслэл /адилтгал, амьдчилал/-ийн учир холбогдлоор тайлбарладаг. |
|   |                                                                                                                                           | Сурагч зохиолын өгүүлэгдэхүүний бүтцийг нь ялган таньдаг.                                        |
|   |                                                                                                                                           | Сурагч зохиолын сэдэв, гол санааг нь тайлбарлаж чаддаг болно.                                    |
|   |                                                                                                                                           | Сурагч зохиолыг задлан шинжилж, үйл явдал өрнөсөн орчны дүрслэлийг ялган таньдаг.                |
|   |                                                                                                                                           | Сурагч зохиолын дүрийн зорилгыг тодорхойлдог.                                                    |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                   | Гүйцэтгэлийн түвшин                                                            |                                                                                                                                         |                                                                                                                                                                     |                                                                                                                                                             |
|--------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                  | I                                                                              | II                                                                                                                                      | III                                                                                                                                                                 | IV                                                                                                                                                          |
| Сурагч зохиолын далд утгыг уран дүрслэл /адилтгал, амьдчилал/-ийн учир холбогдлоор тайлбарладаг. | •Зохиолоос уран дүрслэлийн амьдчилж, адилтгасан дүрслэлийг таньж олдог.        | •Зохиолоос өөртөө танил биш үг хэллэгийг таньж олдог.<br>•Зохиолд юуг, юутай жишин адилтгал, амьдчилал ур маяг ашигласныг тайлбарладаг. | •Зохиолд байгаа танил биш үгийн тохирох утгыг хам бүтцээс нь таамаглаж тайлбарладаг.<br>•Зохиолд амьдчилж, адилтгасан дүрслэлийн далд утгыг таамаглан тайлбарладаг. | •Танил биш үгийн зохиолд тохирох утгыг толь бичгээс олж тайлбарладаг.<br>•Зохиолд амьдчилж, адилтгасан дүрслэлийн далд утгыг жишээгээр батлан тайлбарладаг. |
| Сурагч зохиолын өгүүлэгдэхүүний бүтцийг нь ялган таньдаг.                                        | •Зохиолын агуулгыг эхлэл, гол, төгсгөл хэсгийг ялган таньдаг.                  | •Зохиолын эхлэл, зангилаа /зөрчил үүсгэж буй хэрэг явдал/, өрнөлийг ялган таньдаг.                                                      | •Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл /зөрчил хурцдаж байгаа/-ыг ялган таньдаг.                                                                                    | •Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал / зөрчил шийдэгдэж буй/-ыг ялган таньдаг.                                                                    |
| Сурагч зохиолын сэдэв, гол санааг нь тайлбарлаж чаддаг болно.                                    | •Зохиолын сэдэв, гол санааг өөрийн үгээр тайлбарладаг.                         | •Зохиолын сэдэв, гол санааг дүрийн үг, үйлдэлтэй холбон тайлбарладаг.                                                                   | • Зохиолын сэдэв, гол санааг илэрхийлсэн түлхүүр үг, өгүүлбэрийг олж тайлбарладаг.                                                                                  | •Зохиолын сэдэв, гол санааны уялдаа холбоог дүгнэж тайлбарладаг.                                                                                            |
| Сурагч зохиолыг задлан шинжилж, үйл явдал өрнөсөн орчны дүрслэлийг ялган таньдаг.                | Зохиолын үйл явдал өрнөж буй орон ба цагийн дүрслэлийг асуултаар ялган таньдаг | Зохиолын үйл явдал өрнөж буй орон ба цагийг ямар үгээр дүрсэлснийг ялган таньдаг                                                        | Зохиолын үйл явдал өрнөж буй орон ба цагийн дүрслэлийг нь дүрүүдийн харилцан ярианаас ялган таньдаг.                                                                | •Зохиолын үйл явдал өрнөсөн орон ба цагийн дүрслэлийг гол санаатай холбодог.                                                                                |
| Сурагч зохиолын дүрийн зорилгыг тодорхойлдог.                                                    | Зохиолын дүрүүдийн хэлсэн үг, хийсэн үйлдлийг тодорхойлдог.                    | Зохиолын дүрүүдийн үг, үйлдлээс зан чанарыг нь тодорхойлдог.                                                                            | Зохиолын дүрүүдийг харьцуулж, адил ба ялгаатай талыг тодорхойлдог.                                                                                                  | Зохиолын дүрийн зан чанараас зорилгыг нь тодорхойлдог.                                                                                                      |

## 1.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлгийг дуурайн зохиож, уран унших

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                   | Суралцахуйн үр дүн                                                                                                               |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 6.1ж.Шүлэглэсэн зохиолын шад холбоцыг таних<br>6.2в. Шүлгийн хэлбэрийг дуурайн зохиох<br>6.3б. Шүлэг зохиолоос сонгон цээжилж, дуу хоолойн өнгө, айзам, хэмнэл тохируулан уран унших | Сурагч шүлэглэсэн зохиолын онцлог тохирсон шад мөрийг зохиож чаддаг болсон байна.<br>Сурагч цээжилснээ уран уншдаг болсон байна. |

### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                                | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                                                 |
|---|-----------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч шүлэглэсэн зохиолын онцлог тохирсон шад мөрийг зохиож чаддаг болсон байна. | Сурагч уншсан шүлэглэсэн зохиолын онцлогийг задлан шинжилж, толгой, сүүл холбоц, шадыг ялгадаг.<br>Сурагч шүлгийн толгой, сүүл холбоц, шадыг дуурайн зохиодог. |
| 2 | Сурагч цээжилснээ уран уншдаг болсон байна.                                       | Сурагч дуу хоолойн өнгө, айзам, хэмнэлийг тохируулан уран уншдаг.                                                                                              |

### Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                  | Гүйцэтгэлийн түвшин                                                                                    |                                                                                                   |                                                                                                     |                                                                                                       |
|-------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                 | I                                                                                                      | II                                                                                                | III                                                                                                 | IV                                                                                                    |
| Сурагч уншсан шүлэглэсэн зохиолын онцлогийг задлан шинжилж, толгой, сүүл холбоц, шадыг ялгадаг. | Шүлгийн шад /мөр\ бүрийн эхэн болон сүүл хэсгийг холбодог ижил дуудлагатай авиаг ажиглан, тэмдэглэдэг. | Шүлгийн шад /мөр/-ыг толгой холбоцыг шинжилж, ижил төстэй авиа, үеэр толгой холбодгийг илрүүлдэг. | Шүлгийн шад /мөр/-ыг ижил төстэй авиа, үеэр толгой холбон, мөрийг тэгшлэн зохиодгийг ялган таньдаг. | Шад /Мөр/ бүрийн эхэн, сүүл холбоц нь шүлгийн айзамтай, хэмнэлтэй болгож байгааг батлан тайлбарладаг. |
| Сурагч шүлгийн толгой, сүүл холбоц, шадыг дуурайн зохиодог.                                     | Шүлгийн зарим шад /мөр/-ын үгийн тоо, үгийн хувиллыг дуурайн зохиодог.                                 | Шүлгийн зарим бадгийг дуурайн зохиодог.                                                           | Шүлгийг бүхэлд нь дуурайн толгой, сүүл холбон зохиодог.                                             | Шүлэгт өгүүлсэн зүйлийг өөрчлөн хэлбэрийг нь дуурайн зохиодог.                                        |
| Сурагч дуу хоолойн өнгө, айзам, хэмнэлийг тохируулан уран уншдаг.                               | Цээжилсэн шүлэг, зохиолыг бусдын өмнө өөртөө итгэлгүй уншдаг.                                          | Цээжилсэн шүлэг, зохиолыг бусдын өмнө айзам хэмнэл муутай ч чанга тод дуугаар уншдаг.             | Цээжилсэн шүлэг, зохиолыг бусдын өмнө айзам хэмнэл тохируулан уншихыг оролддог.                     | Цээжилсэн шүлэг, зохиолыг бусдын өмнө айзам хэмнэл тохируулан уран тод уншдаг.                        |

1.2.4. Үнэлгээний нэгж 4. Бичих, ярих

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                   | Суралцахуйн үр дүн                                                |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------|
| <p>6.2а. Уншсан зохиолын сэдэв, гол санаа дүрээс төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлэн бичих</p> <p>6.2б. Уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүй үйл явдлыг товчилж бичих</p> <p>6.3а. Уншсан зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярих</p> | Сурагч уншсан зохиолыг ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг. |

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                             |
|---|-------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч уншсан зохиолыг ойлгосноо амаар болон бичгээр илэрхийлдэг. | Сурагч уншсан зохиолоос төрсөн мэдрэмж, төрсөн сэтгэгдлээ амаар болон бичгээр илэрхийлдэг. |
|   |                                                                   | Сурагч уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүй товчилж бичдэг                            |
|   |                                                                   | Сурагч уншсан зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярьдаг.                          |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                             | Гүйцэтгэлийн түвшин                                                                                 |                                                                                                                     |                                                                                                                               |                                                                                                                    |
|--------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                            | I                                                                                                   | II                                                                                                                  | III                                                                                                                           | IV                                                                                                                 |
| Сурагч уншсан зохиолоос төрсөн мэдрэмж, төрсөн сэтгэгдлээ амаар болон бичгээр илэрхийлдэг. | Зохиолын дүрийн үйлдэл, үг ярианаас төрсөн таатай/ таагүй мэдрэмжээ илэрхийлэн ярьдаг.              | Зохиолын дүр, сэдэв, гол санаанаас төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж, учир шалтгааныг нь тайлбарлан ярьж, бичдэг. | Зохиолын сэдэв, дэвшүүлсэн асуудал /гол санаа/-аас төрсөн мэдрэмж сэтгэгдлээ илэрхийлж, жишээ, баримтаар батлан ярьж, бичдэг. | Зохиолд дэвшүүлсэн асуудлыг өнөөгийн цаг үетэй харьцуулж, өөрт төрсөн сэтгэгдэл мэдрэмжээ илэрхийлэн ярьж, бичдэг. |
| Сурагч уншсан зохиолын гол санааг алдагдуулахгүй товчилж бичдэг                            | Зохиолын цогцолбор бүрийн утгыг ойлгож, гол санааг илэрхийлсэн үг хэллэг, өгүүлбэрийг ялган бичдэг. | Гол санааг илэрхийлсэн үг хэллэг, өгүүлбэрийг хэрэглэн үйл явдлыг товчлон бичдэг.                                   | Гол санааг илэрхийлсэн түлхүүр үг, чухал, содон үг хэллэгийг оруулж товчлон бичдэг.                                           | Зохиолын гол санааг алдагдуулахгүй үйл явдлыг өөрийн үгээр, цөөн өгүүлбэрээр товчилж бичдэг.                       |
| Сурагч уншсан зохиолын үйл явдлыг өөрийн үгээр ойлгомжтой ярьдаг.                          | •Зохиолын үйл явдлыг тоймлон ярьдаг                                                                 | •Зохиолын үйл явдлыг асуулт ашиглан ярьдаг.                                                                         | •Зохиолын үйл явдлыг дарааллыг тулгуур бичиглэл ашиглан тодорхой ярьдаг                                                       | •Зохиолоос эш жишээ баримт ашиглан үйл явдлыг нарийвчлан ойлгомжтой ярьдаг                                         |



**ХОЁРДУГААР БҮЛЭГ. VII АНГИ**

**2.1. VII АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН**

Сурагч уншсан зохиолоос соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд тусган хүлээж авах, задлан шинжлэх, дуурайн зохиох, үйл явдлыг нэмэн дэлгэрүүлж мэдрэмж сэтгэгдлээ бичих, зохиолыг сэтгэл татахаар ярих чадвар эзэмшинэ.

**2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ**

**2.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж ойлгох**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                        | Суралцахуйн үр дүн                                                                                                                              |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7.1а. Монгол ерөөл, магтаал, түүх домог, уянгын ба туульсын яруу найраг, туурь, өгүүллэг, өрнө дорнын шилдэг зохиолоос уншиж, соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээж авах | Сурагч ардын аман зохиолыг мэдэрч ойлгон, тусгаж хүлээж авах, үндэсний хэл соёл, ёс заншлыг хүндэтгэн суралцаж эх оронч үзэл хандлагатай болно. |

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                                                                                              | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                       |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч ардын аман зохиолыг мэдэрч ойлгон, тусгаж хүлээж авах, үндэсний хэл соёл, ёс заншлыг хүндэтгэн суралцаж эх оронч үзэл хандлагатай болно. | Сурагч түүх, домог, хууч яриаг уншиж соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээж авснаа илэрхийлж чаддаг. |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                       | Гүйцэтгэлийн түвшин                                                                      |                                                                                                                  |                                                                                               |                                                                                                                                                |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                      | I                                                                                        | II                                                                                                               | III                                                                                           | IV                                                                                                                                             |
| Сурагч түүх, домог, хууч яриаг уншиж соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд мэдэрч тусган хүлээж авснаа илэрхийлж чаддаг. | Уншсан зохиолын хүрээнд тусган хүлээж авсан цөөн үйл явдлыг тоочин /дурдаж/ илэрхийлдэг. | Уншсан зохиолын соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд тусган хүлээж авснаа дутуу эсвэл тойм төдийгөөр л илэрхийлдэг. | Уншсан зохиолын соёл, түүхийн хам сэдвийн хүрээнд л тусган хүлээж авч мэдэрсэнээ илэрхийлдэг. | Уншсан зохиолын /соёл, түүх/ хам сэдвийн хүрээнд тусган хүлээж авч мэдэрсэнээ өөрийн үзэл бодолтойгоо холбон чөлөөтэй, хангалттай илэрхийлдэг. |

**2.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                              | Суралцахуйн үр дүн                                                                                                                               |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>7.1б. Зохиолчийн үг сонголт, уран дүрслэл (адилтгал, амьдчилал, хэтрүүлэл) -ийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах</p> <p>7.1г. Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлох</p> <p>7.1в. Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц хэсгүүдийн холбоо хамаарлыг тодорхойлох</p> <p>7.1д. Зохиолын орчин, нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлах</p> <p>7.1е. Зохиолын дүрийн шууд ба шууд бус тодорхойлолт (үг, үйлдэл, бодол санаа)-оос дүрийн зан төрхийг тодорхойлж, үнэлэх</p> | <p>Сурагч зохиолын бүтэц - агуулга, хэл найруулга - дүрслэл, сэдэв - гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг задлан шинжилж чаддаг болно.</p> |

**Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

| № | Суралцахуйн үр дүн                                                                                                                        | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч зохиолын бүтэц - агуулга, хэл найруулга - дүрслэл, сэдэв - гол санаа, үйл явдал өрнөсөн орчин, дүрийг задлан шинжилж чаддаг болно. | <p>Сурагч зохиолын далд утгыг уран дүрслэлийн учир холбогдлоор тайлбарлаж чаддаг болно.</p> <p>Сурагч зохиолын сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болно.</p> <p>Сурагч өгүүлэгдэхүүний бүтэц хэсгүүдийн холбоо хамаарлыг тодорхойлж чаддаг болно.</p> <p>Сурагч зохиолын орчин нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлаж чаддаг болно.</p> <p>Сурагч зохиолын дүрийг тодорхойлж, үнэлж чаддаг болно.</p> |

**Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин**

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                       | Гүйцэтгэлийн түвшин                                                                   |                                                                                                            |                                                                                                                      |                                                                                                     |
|--------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                      | I                                                                                     | II                                                                                                         | III                                                                                                                  | IV                                                                                                  |
| Сурагч зохиолын далд утгыг уран дүрслэлийн учир холбогдлоор тайлбарлаж чаддаг болно. | Уран дүрслэл (амьдчилал, адилтгал)-ийн аль нэгийг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг. | Уран дүрслэл (амьдчилал, адилтгал)-ийг хоёуланг нь эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг.                     | Зохиогчийн үг сонголт, уран дүрслэл (амьдчилал, адилтгал)-ийг эхэд хэрэглэсэн учрыг тайлбарладаг.                    | Зохиолчийн үг сонголт /онцлог/, уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг тайлбарладаг.           |
| Сурагч зохиолын сэдэв, гол санааг тодорхойлж чаддаг болно.                           | •Зохиолын сэдэв, гол санааг оновчгүй тодорхойлдог.                                    | Сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрийн аль алинаар нь илэрхийлдэг ч хоёуланг оновчтой бус тодорхойлдог. | • Сэдэв, гол санааг түлхүүр үг, өгүүлбэрийн аль нэгээр нь оновчтой тодорхойлдог.                                     | •Сэдэв, гол санааг оюун дүгнэлт хийж, түлхүүр үг, өгүүлбэрийн аль алинаар нь оновчтой тодорхойлдог. |
| Сурагч өгүүлэгдэхүүний бүтэц хэсгүүдийн холбоо хамаарлыг тодорхойлж чаддаг болно.    | • Эхийн бүтцийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн холбоог л тодорхойлдог                 | Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл /зөрчил үүсгэж буй/-хүртэл тодорхойлдог,                                   | •Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал / зөрчил шийдэгдэж буй/-ыг аль нэгийг буруу эсвэл орхиж тодорхойлдог. | •Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал / зөрчил шийдэгдэж буй/-ыг бүрэн зөв тодорхойлдог.   |

## ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР

|                                                                                                                   |                                                                                        |                                                                                      |                                                                                                                                  |                                                                                                                                   |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолын орчин нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг тайлбарлаж чаддаг болно. | Зохиолын үйл явдал өрнөж буй орон ба цаг заасан үгийг ялган тайлбарладаг.              | Зохиолын орон ба цагийн дүрслэлийг бүрэн олж, орчныг ялган тайлбарладаг.             | Зохиолын орон ба цагийн дүрслэлээр үйл явдлын орчин хэрхэн өөрчлөгдсөнийг зохиолын үг хэллэг, өгүүлбэрээр жишээлэн тайлбарладаг. | Зохиолын орчин нөхцөл байдал нь зохиолын сэдэв, утгыг тодруулахад нөлөөлж байгааг оновчтой зөв тайлбарладаг.                      |
| Сурагч зохиолын дүрийг тодорхойлж, үнэлж чаддаг болно.                                                            | Зохиолын дүрийн зан төрхийн эерэг, сөрөг болохыг цөөн үгээр оновчтой бус тодорхойлдог. | Зохиолын дүрийн зан төрхийн эерэг, сөрөг болохыг зөвхөн үг, үйлдээс нь тодорхойлдог. | Зохиолын дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлээр эерэг, сөрөг болохыг тодруулж үнэлж дүгнэж тодорхойлдог.                              | Зохиолын дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдэл, бодол санаа, эд хэрэглэл зэргээр дүрийн эерэг, сөрөг болохыг үнэлж дүгнэж тодорхойлдог. |

### 2.2.3. Үнэлгээний нэгж 3. Мэдрэмж сэтгэгдлээ бичих

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                                                                                     | Суралцахуйн үр дүн                                                                                                                                                                   |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <p>7.2а. Уншсан зохиолын сэдэв, утга санаа, дүрээс төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ бичих</p> <p>7.2б. Уншсан зохиолд дүр, орчин нэмэх, харилцан яриа оруулах зэргээр үйл явдлыг дэлгэрүүлж бичих</p> <p>7.2в. Ерөөл, магтаалын шүлэглэлийн туршлага, уран дүрслэл (адилтгал, зүйрлэл)-ийн аргаас суралцан, шүлэг зохиох</p> | <p>Сурагч уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр дүрслэлийн талаарх мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохиож бичиж чаддаг болно.</p> |

#### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                                                                                                                            | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                  |
|---|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч уншсан зохиолын сэдэв, гол санаа, дүр дүрслэлийн талаарх мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохиож бичиж чаддаг болно. | Сурагч уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохион бичдэг. |

#### Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                  | Гүйцэтгэлийн түвшин                                    |                                                                                   |                                                                                 |                                                                                                                   |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                 | I                                                      | II                                                                                | III                                                                             | IV                                                                                                                |
| Сурагч уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан зохион бичдэг. | Уншсан зохиолын талаар төрсөн сэтгэгдлээ бичиж чаддаг. | Зохиолоос төрсөн сэтгэгдэл юунаас болж өөрт нь нөлөөлж байгааг тайлбарлаж бичдэг. | Уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ уран дүрслэл ашиглаж бичдэг. | Уншсан зохиолын талаар мэдрэмж сэтгэгдлээ бичихдээ дүр, орчин, харилцан яриа оруулан уран дүрслэл ашиглан бичдэг. |

#### **2.2.4. Үнэлгээний нэгж 4. Зохиолыг ярих**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                          | Суралцахуйн үр дүн                                                                                                                               |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 7.3а. Зохиолын үйл явдлыг ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэлээс эшлэл авч, сонирхол татаж сэтгэлд хүрэхээр ярих<br>7.3б. Зохиолын дүрийн үг үйлдлээр зан төрхийг харуулж, дүрд тоглох | Сурагч зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл ашиглан, сонирхол татаж сэтгэлд хүрэхээр ярьж /дүрд тоглож/ чаддаг болно. |

#### **Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

| № | Суралцахуйн үр дүн                                                                                                                               | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                                               |
|---|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч зохиолын дүрийн талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл ашиглан, сонирхол татаж сэтгэлд хүрэхээр ярьж /дүрд тоглож/ чаддаг болно. | Сурагч зохиолын үйл явдлын талаар ярихдаа үндэсний хэл, соёл, ёс заншлын үнэт зүйлсийн жишээ, баримт, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярьдаг. |

#### **Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин**

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                                                               | Гүйцэтгэлийн түвшин                                  |                                                                       |                                                                                                                      |                                                                                                                       |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                                                                              | I                                                    | II                                                                    | III                                                                                                                  | IV                                                                                                                    |
| Сурагч зохиолын үйл явдлын талаар ярихдаа үндэсний хэл, соёл, ёс заншлын үнэт зүйлсийн жишээ, баримт, эшлэл ашиглан сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярьдаг. | Зохиолын үйл явдлын талаар өөрийн үгээр ярьж чаддаг. | Зохиолын үйл явдлын талаар ярихдаа зохиолын үг хэллэг ашиглаж ярьдаг. | Зохиолын үйл явдлын талаар ярихдаа зохиолын үг хэллэг, уран дүрслэл ашиглаж сонирхол татаж, сэтгэлд хүрэхээр ярьдаг. | Зохиолын үйл явдлын талаар ярихдаа үг, хэллэг, уран дүрслэл, эшлэл ашиглан сэтгэл татахаар ярьж /дүрд тоглох/ чаддаг. |

#### **2.2.5. Үнэлгээний нэгж 5. Бичих, ярих**

| Суралцахуйн зорилт                                 | Суралцахуйн үр дүн                                               |
|----------------------------------------------------|------------------------------------------------------------------|
| 7.1ж. Шүлэглэсэн зохиолын шад, холбоцыг тайлбарлах | Сурагч шүлэглэсэн зохиолын шад холбоцыг тайлбарлаж чаддаг болно. |

#### **Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

| № | Суралцахуйн үр дүн                                               | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                       |
|---|------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч шүлэглэсэн зохиолын шад холбоцыг тайлбарлаж чаддаг болно. | Сурагч шүлэглэсэн зохиолын хэлбэрийг тайлбарлаж чаддаг болсон байна. |

#### **Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин**

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                       | Гүйцэтгэлийн түвшин                                                              |                                                                              |                                                                                                    |                                                                                                                                        |
|----------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                      | I                                                                                | II                                                                           | III                                                                                                | IV                                                                                                                                     |
| Сурагч шүлэглэсэн зохиолын хэлбэрийг тайлбарлаж чаддаг болсон байна. | Шүлгийн толгой холбоц /ижил авиагаар бүрэн толгой холбох/ ба шадыг тайлбарладаг. | Шүлгийн толгой холбоц / авиагаар бүрэн толгой холбох/ ба шадыг тайлбарладаг. | Шүлгийн толгой холбоц /авиа, үеэр бүрэн ба зэрэгцүүлэн холбох/ ба сүүл холбоц, шадыг тайлбарладаг. | Шүлгийн толгой холбоц /ижил авиа, үе, үгээр бүрэн, зэрэгцүүлэн, хашиж холбох/ ба сүүл холбоц, шадыг /3,4,6,8,12 гэх мэт/ тайлбарладаг. |



**ГУРАВДУГААР БҮЛЭГ. VIII АНГИ**

**3.1. VIII АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН**

Сурагч уншсан зохиолоосоо соёл түүх, нийгмийн хүрээнд мэдэрч, тусган хүлээн авахдаа зохиолд дэвшүүлсэн асуудлын талаар санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэн, зохиолыг задлан шинжилж, зохиолоос сэдэвлэн богино хэмжээний өгүүллэг зохиох, шүлэг яруу найргийг уран унших чадвартай болно.

**3.1. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ**

**3.1.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж ойлгох**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                                                       | Суралцахуйн үр дүн                                                                                                                                        |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 8.1.а Монгол баатарлаг туульс, иргэний яруу найраг, өгүүллэг, туурь, тууж, хошин жүжиг, өрнө дорнын шилдэг зохиолоос уншиж, соёл түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээн авах<br>8.3.б Зохиолд дэвшүүлсэн асуудал, хам сэдвийн хүрээнд санаа бодлоо илэрхийлэн хэлэлцэх | Сурагч зохиолыг уншин соёл түүх, нийгмийн хүрээнд мэдэрч, тусган хүлээж авахдаа зохиолд дэвшүүлсэн асуудлын талаар санаа бодлоо илэрхийлдэг болсон байна. |

**Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

|----------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------|
| 9.3а:Бие даан уншсан зохиолыг бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой арга хэлбэрээр танилцуулан илтгэх | Сурагч уншсан зохиолоо сонирхолтой арга хэлбэрээр танилцуулж чаддаг болно. |

#### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| № | Суралцахуйн үр дүн                                                         | Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                |
|---|----------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сурагч уншсан зохиолоо сонирхолтой арга хэлбэрээр танилцуулж чаддаг болно. | Сурагч бие дааж уншсан зохиолоо бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой арга хэлбэрээр танилцуулах илтгэдэг. |

#### Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                                | Гүйцэтгэлийн түвшин                                                        |                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                              |                                                                                                                                                                                                                                              |
|---------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                               | I                                                                          | II                                                                                                                                                                                                                       | III                                                                                                                                                                                                                          | IV                                                                                                                                                                                                                                           |
| Сурагч бие дааж уншсан зохиолоо бусдад унших хүсэл төрөхүйц, сонирхолтой арга хэлбэрээр танилцуулах илтгэдэг. | Бие даан уншсан зохиолоо өөрийн болон зохиолын үгээр танилцуулан илтгэдэг. | Уншсан зохиолоо өөрийн болон зохиолын үгээр, янз бүрийн арга хэлбэр /оюуны зураглал, презентаци, жүжигчилсэн тоглолт,видео бичлэг, тухай зохиолын талаарх ТВ нэвтрүүлэг, ярилцлага/ -ээс зарим нэгийг хэрэглэн илтгэдэг. | Бие даан уншсан зохиолоо өөрийн болон зохиолын үгээр, янз бүрийн арга хэлбэр /оюуны зураглал, презентаци, жүжигчилсэн тоглолт,видео бичлэг, тухай зохиолын талаарх ТВ нэвтрүүлэг, ярилцлага/-ээс нэлээдийг ашиглан илтгэдэг. | Бие даан уншсан зохиолоо өөрийн болон зохиолын үгээр, янз бүрийн арга хэлбэрүүд /оюуны зураглал, презентаци, жүжигчилсэн тоглолт,видео бичлэг, тухай зохиолын талаарх ТВ нэвтрүүлэг, ярилцлага зэргийг ашиглан/ -ийг өргөн ашиглан илтгэдэг. |



## **БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН**

### **УРАН ЗОХИОЛ**

*ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР*

Нэгдүгээр бүлэг - X анги  
Хоёрдугаар бүлэг - XI анги  
Гуравдугаар бүлэг - XII анги  
Дөрөвдүгээр бүлэг - IX анги





## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Х АНГИ

### 1.1. Х АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Бүрэн дунд боловсролын уран зохиолын хичээлээр зохиолд суурилж зохиогч ба хам сэдэвт төвлөрсөн уншлага өрнүүлсний үндсэн дээр задлан шинжилж, тайлан тайлбарлах чадвартай болсон байна.

### 1.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

#### 1.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, ойлгох

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                   | Суралцахуйн үр дүн                                                                  |
|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|
| 10.1а. Монголын эртний уран зохиол, өөр өөр цаг үеийн уянга, туульс, жүжгийн зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгох | Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. |
| 10.3а. Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэн харилцах                                                                                       |                                                                                     |

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                                                  | Шалгуур                                                                     |
|-------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. | Сурагч зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг.        |
|                                                                                     | Сурагч уншсан зохиолын хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлдэг. |
|                                                                                     | Сурагч үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгосноо илэрхийлдэг.            |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                              | Гүйцэтгэлийн түвшин                                                                           |                                                                                                                                          |                                                                                                                                                            |                                                                                                                                                                          |
|-----------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                             | I                                                                                             | II                                                                                                                                       | III                                                                                                                                                        | IV                                                                                                                                                                       |
| Сурагч зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг.        | Түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг /ерөнхий ойлголт/ илэрхийлдэг. | Зохиолын доторх үг, өгүүлбэрт үндэслэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдвийн алинд хамаарч байгааг тогтоож, юуг тусган авснаа илэрхийлдэг. | Зохиолд /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэвт ямар асуудал дэвшүүлсэн, ямар хэрэг явдлаар үзүүлснийг өөрийн үзэл бодол, байр суурьтай холбон илэрхийлдэг.     | Зохиолд дэвшүүлсэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэв юуг бодогдуулсан, далд /ил/ утгыг тайлж байгаа өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлдэг.                          |
| Сурагч уншсан зохиолын хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлдэг. | Бусдын санал бодлыг хүлээцтэй сонсдог, сэтгэгдлээ илэрхийлдэг                                 | Уншсан зохиолын хүрээнд асуулт тавьдаг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлдэг.                          | Уншсан зохиолын хүрээнд асуулт асууж, хариулт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлдэг.                    | Уншсан зохиолын хүрээнд шүүмжлэн дүгнэлт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг.                                           |
| Сурагч үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгосноо илэрхийлдэг.            | Зохиолын хэрэг явдлаас өөрт хэрэгтэй эерэг зүйлийн талаарх ойлголтоо илэрхийлдэг.             | Зохиолын утга, агуулгаас өөрт болоод бусдад хэрэгтэй сургамж, үлгэрлэж болох зүйлийн талаарх ойлголтоо илэрхийлдэг.                      | Зохиолоос үндэсний онцлог ялгааг харуулж буй хэсгийг сонгосноо; утга, агуулгаас амьдрахуйд, ёс зүйтэй болоход үлгэрлэсэн чухал зүйл ойлгосноо илэрхийлдэг. | Зохиолоос үндэсний онцлог илэрсэн хэсгийг сонгож, нийтлэг ижилслийг; зохиолын утга, агуулгаас хүний амьдрал, зан чанар, бахархал зэрэг чухал зүйл ойлгосноо илэрхийлдэг. |

**1.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх**

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                                                | Суралцахуйн үр дүн                                                                             |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------|
| 10.1б. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах<br>10.1в. Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарлах                                                                                                      | Сурагч зохиолын бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарал ба дүрийн шинжийг тайлбарладаг болсон байна. |
| 10.1г. Зохиолын бодит ба хийсвэр дүр нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах<br>10.1д. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох                                                                                               | Сурагч зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.                          |
| 10.2б. Уншсан зохиолоос сэдэвлэн, хувирган зохиож, богино өгүүллэг туршин бичих                                                                                                                                                                                                   | Сурагч зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.                |
| 10.1ж. Зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг задлан шинжлэх.<br>10.2а. Уншсан зохиолын уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэл, хэлний хэрэглээг задлан шинжилж, үндэслэлтэй, баримт нотолгоотой, үнэлж дүгнэн бичих | Сурагч зохиолын хэл найруулгын нөлөө ба хэлний хэрэглээг үнэлж дүгнэдэг болсон байна.          |

**Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

| Суралцахуйн үр дүн                                                                             | Шалгуур                                                                                                        |
|------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолын бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарал ба дүрийн шинжийг тайлбарладаг болсон байна. | Сурагч зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарладаг.                                 |
|                                                                                                | Сурагч зохиолын бодит ба хийсвэр дүрийг тайлбарладаг.                                                          |
| Сурагч зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.                          | Сурагч зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог.                                      |
| Сурагч зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.                | Сурагч сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.                               |
|                                                                                                | Сурагч зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг. |
| Сурагч зохиолын хэл найруулгын нөлөө ба хэлний хэрэглээг үнэлж дүгнэдэг болсон байна.          | Сурагч зохиолын хэлний хэрэглээг үндэслэлтэй, баримт нотолгоотой, үнэлж дүгнэн бичдэг.                         |

## Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                   | Гүйцэтгэлийн түвшин                                                                                     |                                                                                                                      |                                                                                                                                                                                         |                                                                                                                                                                                                                                     |
|----------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                  | I                                                                                                       | II                                                                                                                   | III                                                                                                                                                                                     | IV                                                                                                                                                                                                                                  |
| Сурагч зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарладаг.   | Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайлал хоорондын холбоо хамаарлыг тайлбарладаг.                  | Зохиолын өгүүлэгдэхүүн хоорондын болон хүүрнэн өгүүлэгчийн мэдээлсэн орон, цагийн холбоо хамаарлыг тайлбарладаг.     | Зохиолын өгүүлэгдэхүүн хоорондын болон хүүрнэн өгүүлэгч хэддүгээр биеэс өгүүлсэн хийгээд мэдээлсэн орон, цаг, дуу хоолойн холбоо хамаарлыг тайлбарладаг.                                | Зохиолын өгүүлэгдэхүүн хоорондын болон хүүрнэн өгүүлэгч хэддүгээр биеэс өгүүлсэн хийгээд мэдээлсэн орон, цаг, дуу хоолойн үүргийн холбоо хамаарлыг тайлбарладаг.                                                                    |
| Сурагч зохиолын бодит ба хийсвэр дүрийг тайлбарладаг.                            | Дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс нөхцөл байдлыг тайлбарладаг.                                          | Дүрийн бодит шинжийг түүхэн нөхцөл байдалтай, хийсвэр шинжийг уран сайхны талаас хэрхэн хийсвэрлэснийг тайлбарладаг. | Бодит ба хийсвэр дүрийн шинжийг зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдлээс нь; зохиолын сэдэв, утга санаанд хэр нөлөөлснийг; дүр бүтээснээрээ уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг тайлбарладаг. | Бодит ба хийсвэр дүрийн шинжийг зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдлээс нь; зохиолын сэдэв, утга санаанд хэр нөлөөлснийг; нөхцөл байдалд татан оруулж буй шалтгааныг; дүр бүтээснээрээ уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг тайлбарладаг. |
| Сурагч зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог.        | Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог.                                      | Зохиолд үзүүлж буй орон, цаг дүртэй холбогдож буйг тодорхойлдог.                                                     | Гадаад буюу орчин, нөхцөл байдал нь, мөн дотоод орчин буюу тэдний харилцаа дүрийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог.                                                                | Гадаад буюу орчин, нөхцөл байдал нь, мөн дотоод орчин буюу тэдний харилцаа, уур амьсгал нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог.                                                                                            |
| Сурагч сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг. | Зохиолд хүний амьдрал, үзэгдэл юмсын талаарх сэдвээр ямар далд санаа бүтээснийг таамаглан тайлбарладаг. | Зохиолын сэдэв, дэд сэдвүүдийн уялдааг зохиолчийн үзэл бодолтой холбон далд утга санаа бүтээснийг тайлбарладаг.      | Зохиолын хам сэдвийг дүр, дүрслэлийн аль нэгтэй холбож, далд утга санааг хэрхэн бүтээснийг тайлан тайлбарладаг.                                                                         | Зохиолын хам сэдэв нь зохиолын дүр, дүрслэлтэй хэрхэн холбогдож, ямар далд /ил/ санааг уран дүрслэлээр бүтээснийг тайлан тайлбарладаг.                                                                                              |

|                                                                                                                |                                                                                                                                                                    |                                                                                                                                                                                                |                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                           |
|----------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг. | Зохиолын үг сонголт, үгийн сан; уран дүрслэл /адилтгал, егөөдөл, бэлгэдэл гэх мэт/-ийн үүрэг, утгыг тайлдаг.                                                       | Зохиолын үг сонголт /уран дүрийн үг;/ үгийн сан /шинэ, хуучин, гадаад гм;/ уран дүрслэл /адилтгал, егөөдөл, бэлгэдэл гэх мэт;/ бичил дүрслэлийн жишээ сонгож уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг. | Зохиолын үг сонголт /уран дүрийн үг;/ үгийн сан /шинэ, хуучин, гадаад гм;/ уран дүрслэл /адилтгал, егөөдөл, бэлгэдэл гэх мэт;/ бичил дүрслэл, яруу хэрэглүүрийг жишээ сонгож уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг.            | Зохиолын үг сонголт /уран дүрийн үг;/ үгийн сан /шинэ, хуучин, гадаад гм;/ уран дүрслэл /адилтгал, егөөдөл, бэлгэдэл гэх мэт;/ бичил дүрслэл, яруу хэрэглүүр уншигчдад хэрхэн нөлөөлж буйг жишээ баримтаар тайлдаг.       |
| Сурагч зохиолын хэлний хэрэглээг үндэслэлтэй, баримт нотолгоотой, үнэлж дүгнэн бичдэг.                         | Сонгосон эшлэлийн уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийг тайлбарлаж бичдэг.                                                                                | Сонгосон үг хэллэг, эшлэлийн уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэл болон оновчтой хэрэглэсэн үг болохыг дүгнэж бичдэг.                                                                   | Уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэл болон зохиолоос үгсийн сангаас оновчтой сонгож хэрэглэсэн үг нь зохиолын сэдэв, утга тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг баримт нотолгоотой, үнэлж дүгнэн бичдэг.              | Уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэл болон зохиолын үгсийн сангаас оновчтой сонгож хэрэглэсэн үг нь сэтгэл хөдлөл, утга хийгээд дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг баримт нотолгоотой, үнэлж дүгнэн бичдэг. |
|                                                                                                                | Зохиол дахь танил бус үгийн тайлбарыг таамаглан тайлж бичдэг.                                                                                                      | Дүрийн үг, зохиолчийн сонгон хэрэглэсэн үг, хэллэгийн утгыг заримыг нь таамаглан, заримыг нь үндэслэлтэй тайлж бичдэг.                                                                         | Дүрийн үгийн сан, зохиолчийн сонгон хэрэглэсэн үг, хэллэгийн утгыг үндэслэлтэй тайлж бичдэг.                                                                                                                              | Дүрийн үгийн сан, зохиолчийн сонгон хэрэглэсэн үг, хэллэгийн утга, үүргийг үндэслэлтэй тайлж бичдэг.                                                                                                                      |
|                                                                                                                | Зохиолоос сэдэвлэн хувиргаж зохиохдоо орон цагийн тохироо болон хэрэг явдлын дарааллаа алдагдуулсан, уран дүрслэл, хэл найруулга оновчгүй, уран сэтгэмжгүй бичдэг. | Зохиолоос сэдэвлэн хувиргаж зохиохдоо орон цагийн тохироо хэрэг явдлын дараалалтай, дүр, орчин, уран дүрслэл, хэл найруулга зарим хэсэгтээ оновчгүй, энгийн сэтгэж бичдэг.                     | Зохиолоос сэдэвлэн хувиргаж зохиохдоо орон цагийн тохироо хэрэг явдлын дараалалтай, дүр, орчин, уран дүрслэл, хэл найруулга оновчтой, хэсгүүдийн уялдаа холбоо бага зэрэг алдагдсан ч уншигчид нөлөөлөхүйц зохион бичдэг. | Зохиолоос сэдэвлэн хувиргаж зохиохдоо орон цагийн тохироо хэрэг явдлын дараалалтай, дүр, орчин, уран дүрслэл, хэл найруулга оновчтой, хэсгүүдийн уялдаа холбоо алдагдаагүй, уншигчид нөлөөлөхүйц сэтгэж зохион бичдэг.    |

### 1.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлэглэсэн зохиол

| Суралцахуйн зорилт                                          | Суралцахуйн үр дүн                                        |
|-------------------------------------------------------------|-----------------------------------------------------------|
| 10.1е. Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг тайлбарлах | Сурагч яруу найргийн онцлогийг тайлбарладаг болсон байна. |

#### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                        | Шалгуур                                      |
|-----------------------------------------------------------|----------------------------------------------|
| Сурагч яруу найргийн онцлогийг тайлбарладаг болсон байна. | Сурагч яруу найргийн онцлогийг тайлбарладаг. |

#### Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур               | Гүйцэтгэлийн түвшин                                                    |                                                                                                     |                                                                                                                                                          |                                                                                                                                                                                     |
|----------------------------------------------|------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                              | I                                                                      | II                                                                                                  | III                                                                                                                                                      | IV                                                                                                                                                                                  |
| Сурагч яруу найргийн онцлогийг тайлбарладаг. | Жишээнд тулгуурлан зөвхөн шүлгийн толгой сүүл холбоцыг л тайлбарладаг. | Судалж буй шүлгийн шадыг зөв үелж, айзам хэмнэлийг, толгой, сүүл холбоцоос бадаглалыг тайлбарладаг. | Авианы давталтад тулгуурлан айзам хэмнэлийг, эгшиг авианы зохицлоос эгшиглэл /эгшиг аялгуу/-ийг, шад ба холбоцоос бадаглалыг аль ч шүлгээс тайлбарладаг. | Авианы давталтад тулгуурлан айзам хэмнэлийг, эгшиг авианы зохицлоос эгшиглэл /эгшиг аялгуу/-ийг, шад ба холбоцоос бадаглал /толгой, сүүл холбох ёс /-ыг аль ч шүлгээс тайлбарладаг. |



## ХОЁРДУГААР БҮЛЭГ. XI АНГИ

### 2.1. XI АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Бүрэн дунд боловсролын уран зохиолын хичээлээр зохиолд суурилж зохиогч ба хам сэдэвт төвлөрсөн уншлага өрнүүлсний үндсэн дээр задлан шинжилж, тайлан тайлбарлах чадвартай болсон байна.

### 2.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

#### 2.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, ойлгох

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                    | Суралцахуйн үр дүн                                                                  |
|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|
| 11.1а. Өрнө дорны өөр өөр соёлын уран зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгох 11.3а. Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцэх | Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. |

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                                                  | Шалгуур                                                              |
|-------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. | Сурагч зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг. |
|                                                                                     | Сурагч уншсан зохиолын хүрээнд үзэл бодлоо илэрхийлдэг               |
|                                                                                     | Сурагч нийгэм соёлын олон янз байдлыг ойлгосноо илэрхийлдэг.         |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                       | Гүйцэтгэлийн түвшин                                                                       |                                                                                                                                                                   |                                                                                                                                                              |                                                                                                                                                                                   |
|----------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                      | I                                                                                         | II                                                                                                                                                                | III                                                                                                                                                          | IV                                                                                                                                                                                |
| Сурагч зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг. | Нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг /ерөнхий ойлголтоо/ илэрхийлдэг. | Зохиолын доторх үг, өгүүлбэрээр дамжуулан /нийгэм, соёл/-ын хам сэдвийн алинд хамаарч байгааг тогтоож, /хэрэг явдал, хүний сэтгэл/ юуг тусган авснаа илэрхийлдэг. | Зохиолд /нийгэм, соёл/-ын хам сэдэвт ямар асуудал дэвшүүлснийг /хэрэг явдал, хүний сэтгэлийг үзүүлсэн нь/ бичвэр, уншигч гэсэн талаас харьцуулж илэрхийлдэг. | Зохиолд дэвшүүлсэн /нийгэм, соёл/-ын хам сэдэвт хэрэг явдал нь /хүний сэтгэлийг үзүүлсэн нь/ юуг бодогдуулсан /зохиогч, бичвэр, уншигч гэсэн гурав/ талаар харьцуулж илэрхийлдэг. |
| Сурагч уншсан зохиолын хүрээнд үзэл бодлоо илэрхийлдэг               | Бусдын санал бодлыг хүлээцтэй сонсдог, сэтгэгдлээ илэрхийлдэг                             | Уншсан зохиолын хүрээнд асуулт тавьдаг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, үзэл бодлоо илэрхийлдэг.                                                            | Уншсан зохиолын хүрээнд асуулт асууж, хариулт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, үзэл бодлоо эшлэл, жишээгээр илэрхийлдэг.                         | Уншсан зохиолын хүрээнд шүүмжлэн дүгнэлт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо эшлэл, жишээ сонгож чөлөөтэй илэрхийлдэг.                                |
| Сурагч нийгэм соёлын олон янз байдлыг ойлгосноо илэрхийлдэг.         | Зохиолын агуулга дахь он тооллоор нийгэм цаг үеийн байдлыг ерөнхий илэрхийлдэг.           | Зохиолын агуулга дахь он тооллоор нийгэм цаг үеийн байдал, соёлын байдлыг тоймлон илэрхийлдэг.                                                                    | Зохиолоос нийгэм цаг үе, цаг үе нийгмийн болон соёлын янз байдал туссаныг жишээ авч илэрхийлдэг.                                                             | Зохиолоос нийгэм цаг үе, цаг үе нийгмийн, соёлын онцлог илэрсэн хэсгийг сонгож, ямар үр нөлөө үзүүлснийг илэрхийлдэг.                                                             |

### 2.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх

| Суралцахуйн зорилт                                                                                                            | Суралцахуйн үр дүн                                                                         |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------|
| 11.1в. Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоог таньж, утга санаанд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох. | Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна.        |
| 11.1г. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тодорхойлох                                | Сурагч зохиолын орчин нь дүр ба сэдэвт нөлөөлж буйг тодорхойлдог.                          |
| 11.1б. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах.                                | Сурагч зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг.                  |
| 11.1д. Зохиолын гадаад ба дотоод орчныг задлан шинжилж, дүр ба сэдвийг тодруулахад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох.        |                                                                                            |
| 11.1ж. Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг задлан шинжлэх.        |                                                                                            |
| 11.2а. Зохиолын утга бүтцийн онцлогийг задлан шинжилж бичихдээ холбогдох нэр томьёог хэрэглэх                                 | Сурагч зохиолын нэр томьёог хэрэглэх болон тодорхой сэдвийн хүрээнд дуурайн зохион бичдэг. |
| 11.2б. Өрнө, дорны яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд санаагаа хөгжүүлэн дүрслэн зохиох           |                                                                                            |

#### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                                                         | Шалгуур                                                                                                    |
|--------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна.        | Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлох. |
|                                                                                            | Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог.                      |
| Сурагч зохиолын орчин нь дүр ба сэдэвт нөлөөлж буйг тодорхойлдог.                          | Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүр ба сэдвийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог.                   |
| Сурагч зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг.                  | Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.                                  |
|                                                                                            | Зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг.    |
| Сурагч зохиолын нэр томьёог хэрэглэх болон тодорхой сэдвийн хүрээнд дуурайн зохион бичдэг. | Зохиолыг шинжлэхдээ холбогдох нэр томьёог хэрэглэн бичдэг.                                                 |
|                                                                                            | Яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд дүрслэн зохиодог.                           |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                                             | Гүйцэтгэлийн түвшин                                                                                           |                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                             |
|------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                                            | I                                                                                                             | II                                                                                                                                                                       | III                                                                                                                                                                                                      | IV                                                                                                                                                                                                                                          |
| Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлох. | Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллын уялдааг холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог.   | Зохиолын өгүүлэгдэхүүний уялдааг холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлохоос гадна зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/-ийг олж тодорхойлдог. | Зохиолын өгүүлэгдэхүүн болон зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал, харилцан яриа, дотоод яриа гэх мэт/ -ийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/ хийж тодорхойлдог. | Зохиолын өгүүлэгдэхүүн болон зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/ ба хүүрнэлийн дуу хоолойн үүргийг утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/ хийж тодорхойлдог.                                                    |
| Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог.                      | Дүр нь өвөрмөц зан төрхөөрөө эсвэл нийтлэг шинжээрээ ялгарч байгааг ерөнхийлэн тодорхойлдог.                  | Дүр нь өвөрмөц зан төрхөөрөө эсвэл нийтлэг шинжээрээ ялгарч байгааг эшилж тодорхойлдог.                                                                                  | Бодгаль ба нийтлэг шинжийг зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдэл нь зохиолын сэдэв, утга санаанд нөлөөлснийг, мөн зохиолч дүр бүтээснээрээ уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг тодорхойлдог.                  | Дүрийн зан чанар, үйл хэрэг нь зохиолын эхнээс аваад төгсгөл хүртэл яаж өөрчлөгдсөнийг ажиглаж /Зохиолд дүрийн сэтгэл зүйг нээн харуулсан уу, дүрийн үзэл санааны зөрчлийг үзүүлсэн үү/ сэдэв, утгад хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлдог.   |
| Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүр ба сэдвийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог.                   | Зохиолд үзүүлж буй орон, цаг болон орчин нь /бодит, хийсвэр эсэх/ дүртэй хэрхэн холбогдож буйг тодорхойлдог.  | Зохиолд үзүүлж буй орон, цаг болон орчин нь /бодит, хийсвэр эсэх/ дүрийн зан чанар, үйл хэрэгт нөлөөлж буйг тодорхойлдог.                                                | Зохиолын орон цаг, орчин нь /бодит, хийсвэр эсэх/; орчны үзэгдэл юмс, нарийн ширийн зүйлс нь дүрийн зан чанар, зорилго, үйл хэргийг хэрхэн өөрчилж, дүрийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог.        | Зохиолын орон цаг, орчин нь /бодит, хийсвэр эсэх/; орчны үзэгдэл юмс, нарийн ширийн зүйлс нь; дүрийн зан чанар, зорилго, үйл хэргийг хэрхэн өөрчилж, дүр болон зохиолын сэдэвт нөлөөлж буйг тодорхойлдог.                                   |
| Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.                                  | Зохиолд хүний амьдрал, үзэгдэл юмсын талаар хэрхэн өгүүлсэн, ямар далд санаа бүтээснийг ерөнхий тайлбарладаг. | Зохиолын үндсэн сэдэв, хам сэдвүүд /нийгэм, соёл/-ийн үгээр "хэлсэн" шууд/ ил/ ба далд утгыг тайлбарладаг.                                                               | Зохиолын хам сэдэвт ямар далд санааг уран дүрслэл бүхий үгээр бүтээснийг, үзэл бодол, үнэт зүйлсийн талаар "үгээр үл хэлсэн" далд утга санааг тайлан тайлбарладаг.                                       | Зохиолд үзэл суртал, соёлын онцлогийг тусгаж ямар ялгаатай утга санаа бүтээснийг; хам сэдэвт ямар далд санааг уран дүрслэл бүхий үгээр бүтээснийг; үзэл бодол, үнэт зүйлсийн талаар "үгээр үл хэлсэн" далд утга санааг тайлан тайлбарладаг. |

|                                                                                                         |                                                                                                                            |                                                                                                                                                                         |                                                                                                                                                         |                                                                                                                                                                           |
|---------------------------------------------------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг. | Зохиолоос утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэг нь зохиолын утгад хэрхэн нөлөөлж байгааг тайлдаг.                             | Зохиолоос утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэг нь зохиолын утга болон уншигчид хэрхэн нөлөөлж байгааг тайлдаг.                                                            | Зохиолоос утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүр нь зохиолын утга болон уншигчид хэрхэн нөлөөлж байгааг тайлдаг.              | Зохиолоос утга шилжүүлэн дүрсэлсэн үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүр нь зохиолын утга болон уншигчид хэрхэн нөлөөлж байгааг жишээ баримтаар тайлдаг.                |
| Зохиолыг шинжлэхдээ холбогдох нэр томьёог хэрэглэн бичдэг.                                              | Зохиолын утга, бүцтийн онцлогийг задалж шинжилж бичихдээ холбогдох нэр томьёог хэрэглээгүй эсвэл оновчгүй хэрэглэж бичдэг. | Зохиолын утга, бүцтийн онцлогийг задалж шинжилж бичихдээ үгийн холбогдох нэр томьёо, эшлэлийг зарим хэсэгтээ оновчгүй /хашилт, хаалтыг гм хэрэглээгүй/ хэрэглэж бичдэг. | Зохиолын утга, бүцтийн онцлогийг задалж шинжилж бичихдээ холбогдох нэр томьёо, эшлэл зүүлтийг оновчтой хэрэглэж цэг цэглэлийн дүрмийг баримталж бичдэг. | Зохиолын утга, бүцтийн онцлогийг задалж шинжилж бичихдээ холбогдох нэр томьёо, эшлэл зүүлт, тайлбар зэргээс оновчтой хэрэглэж цэг цэглэлийн дүрмийг баримталж бичдэг.     |
| Яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд дүрслэн зохиодог.                        | Яруу найргийн хэлбэрийг дуурайсан ч бүтцийг алдагдуулсан, хэл найруулга оновчгүй, уран сэтгэмжгүй бичдэг.                  | Яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн бичихдээ шүлгийн тогтсон хэлбэр бүтцэд тохируулж бүтээсэн ч уншигчид нөлөөлөх уран дүрслэл ашиглаагүй бичдэг.                      | Яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн бичихдээ шүлгийн тогтсон хэлбэр бүтцэд тохируулж, уншигчид нөлөөлөх уран дүрслэлийг сонгож бичдэг.                 | Яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн бичихдээ шүлгийн тогтсон хэлбэр бүтцэд тохируулж, уншигчид нөлөөлсөн дүр дүрслэлтэй, хэл найруулга оновчтой, уран сэтгэмжтэй бичдэг. |

**2.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлэглэсэн зохиол**

| Суралцахуйн зорилт                           | Суралцахуйн үр дүн                                                     |
|----------------------------------------------|------------------------------------------------------------------------|
| 11.1е. Яруу найргийн хэлбэр, бүтцийг шинжлэх | Сурагч яруу найргийн хэлбэр, бүтцийн онцлогийг шинжилдэг болсон байна. |

**Суралцахуйн үр дүнгийн шалгуур**

| Суралцахуйн үр дүн                                                     | Шалгуур                                                                                                            |
|------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч яруу найргийн хэлбэр, бүтцийн онцлогийг шинжилдэг болсон байна. | Сурагч зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог. |

**Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин**

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур           | Гүйцэтгэлийн түвшин                                                                      |                                                                                                                  |                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                |
|------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                          | I                                                                                        | II                                                                                                               | III                                                                                                                               | IV                                                                                                                                                                                                                                             |
| Яруу найргийн хэлбэр, бүтцийг шинжилдэг. | Яруу найргийн хэлбэр бүтцийг задлан шинжлэхдээ зөвхөн шад, бадгийг ерөнхийлөн шинжилдэг. | Яруу найргийн хэлбэр бүтцийн онцлогийг задлан шинжлэхдээ шад болон толгой, сүүл холбоцын байгуулалтыг шинжилдэг. | Яруу найргийн хэлбэр бүтцийн онцлогийг задлан шинжлэхдээ шад, толгой, сүүл холбоц, тогтсон хэлбэр, зохион байгуулалтыг шинжилдэг. | Яруу найргийн хэлбэр бүтцийн онцлогийг задлан шинжлэхдээ шад, толгой, сүүл холбоц, тогтсон хэлбэр, зохион байгуулалт болон уншигчид /байгалийн зураглал, уянгын баатрын сэтгэл хөдлөл, уран дүрслэл, яруу хэрэглүүр гм/ нөлөөлснийг шинжилдэг. |



ГУРАВДУГААР БҮЛЭГ. XII АНГИ

3.1. XII АНГИЙН УРАН ЗОХИОЛЫН ХИЧЭЭЛИЙН СУРАЛЦАХУЙН ҮР ДҮН

Бүрэн дунд боловсролын уран зохиолын хичээлээр зохиолд суурилж зохиогч ба хам сэдэвт төвлөрсөн уншлага өрнүүлсний үндсэн дээр задлан шинжилж, тайлан тайлбарлах чадвартай болсон байна.

3.2. ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ

3.2.1. Үнэлгээний нэгж 1. Зохиолыг уншиж, ойлгох

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                                                                                         | Суралцахуйн үр дүн                                                                  |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------|
| “12.1а. Монголын орчин үеийн уянга, туульс, жүжгийн зохиолыг уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгох<br>12.3а. Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцэх | Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. |

Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                                                  | Шалгуур                                                                           |
|-------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. | Сурагч зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг.              |
|                                                                                     | Сурагч уншсан зохиолын хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцдэг.                 |
|                                                                                     | Сурагч хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгосноо илэрхийлдэг. |

Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                | Гүйцэтгэлийн түвшин                                                                          |                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                            |
|---------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                               | I                                                                                            | II                                                                                                                                                                  | III                                                                                                                                                                                                              | IV                                                                                                                                                                                                                                         |
| Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг. | Нийгэм, соёл, намтрын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг ерөнхий тоймлож илэрхийлдэг. | Зохиолд /түүх, нийгмийн, намтрын,соёлын, шинжлэх ухааны, гүн ухааны, угсаатны гэх мэт/ ямар хам сэдвийг дэвшүүлснийг; хам сэдэв нь юуг бодогдуулж буйг илэрхийлдэг. | Зохиолд /түүх, нийгмийн, намтрын,соёлын, шинжлэх ухааны, гүн ухааны, угсаатны гэх мэт/ ямар хам сэдвийг дэвшүүлснийг; хам сэдвээс юуг тусган авснаа өөрийн үзэл бодлоор илэрхийлдэг.                             | Зохиолд /түүх, нийгмийн, намтрын,соёлын, шинжлэх ухааны, гүн ухааны, угсаатны гэх мэт/ ямар хам сэдвийг дэвшүүлснийг; хам сэдэвт ямар асуудал хөндсөнийг / далд, ил санаагаар/ тайлж байгаагаа өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлдэг. |
| Уншсан зохиолын хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцдэг.    | Дэвшүүлсэн асуудлын хүрээнд бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, саналаа илэрхийлдэг.       | Дэвшүүлсэн асуудлын хүрээнд нотолгоо, нялцаалтын жишээ сонгодог ч байр сууриа хамгаалах, шийдвэрлэхэд хангалтгүй хандаж мэтгэлцдэг.                                 | Дэвшүүлсэн асуудлын хүрээнд нотлох, няцаах талын аль нэг талыг баримталдаг, дэвшүүлсэн нотолгоонуудаас сонгон байр сууриа хамгаалах, хамгийн үнэмшилтэй, үнэн, зөв болсныг шийдвэрлэхэд шүүмжлэл өгч мэтгэлцдэг. | Дэвшүүлсэн асуудлын хүрээнд нотолгоо болон няцаалтуудыг аль ч талаар баталж, дэвшүүлсэн нотолгоонуудаас сонгон байр сууриа хамгаалах, хамгийн үнэмшилтэй, үнэн, зөв болсныг шийдвэрлэхэд дүгнэлт хийж мэтгэлцдэг.                          |

|                                                                            |                                                                                          |                                                                                               |                                                                                                                                                                                                               |                                                                                                                                                                                     |
|----------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгосноо илэрхийлдэг. | Зохиолын утга, агуулгаас хүний эерэг, сөрөг мөн чанарын талаарх ойлголтоо л илэрхийлдэг. | Зохиолын утга, агуулгаас хүний мөн чанар, соёл, нийгмийн тухай ойлголтуудыг товч илэрхийлдэг. | Зохиолын утга, агуулгаас хүний мөн чанарыг; эдийн болон оюуны ямар соёл бүтээснийг; төрт ёс, нийгмийн байгуулал, хөгжлийг ойлгосноо жишээ баримтаар /зарим жишээ нь оновчгүй, баталгаа болохгүй/ илэрхийлдэг. | Зохиолын утга, агуулгаас хүний мөн чанарыг; эдийн болон оюуны ямар соёл бүтээснийг; төрт ёс, нийгмийн байгуулал болоод хөгжлийг ойлгосноо жишээ баримтаар бүрэн баталж илэрхийлдэг. |
|----------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

### 3.2.2. Үнэлгээний нэгж 2. Зохиолыг задлан шинжлэх

| Суралцахуйн зорилт                                                                                                                                                                             | Суралцахуйн үр дүн                                                                              |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------|
| 12.2б. Зохиолын хэлбэр бүтэц, хэл найруулгаас суралцан, уран дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиох. 12.3б. Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэх | Сурагч зохиолын бүтэц, зохиомжийн нэгж ба дүрийн хэв шинжийг дүгнэж, тайлбарладаг болсон байна. |
| 12.1б. Зохиолын сэдэв, утга санаа, хам сэдвийн холбоо хамаарлаар далд утгыг тайлан тайлбарлах                                                                                                  | Сурагч зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг болсон байна.                       |
| 12.1в. Зохиолын өгүүлэгдэхүүн, зохиомжийн нэгжүүдийг ялгаж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэх                                                                                            | Сурагч зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.                 |
| 12.1г. Зохиолын дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд хэрхэн нөлөөлж буйг тайлбарлах                                                                                                     | Сурагч зохиолын хэл найруулга, хэлний хэрэглээнээс суралцдаг болсон байна.                      |
| 12.1д. Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг задлан шинжлэх                                                                                                |                                                                                                 |
| 12.1ж. Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэх, үнэлэх                                                                          |                                                                                                 |
| 12.2а. Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ, тайлбар, нэр томьёог оновчтой хэрэглэх                                                                         |                                                                                                 |

#### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                                                              | Шалгуур                                                                                                          |
|-------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолын бүтэц, зохиомжийн нэгж ба дүрийн хэв шинжийг дүгнэж, тайлбарладаг болсон байна. | Зохиолын зохиомж ба өгүүлэгдэхүүн бүтэц нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэдэг.                            |
|                                                                                                 | Дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд нөлөөлж буйг тайлбарладаг.                                           |
| Сурагч зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг болсон байна.                       | Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг.                                           |
| Сурагч зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.                 | Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.                                        |
|                                                                                                 | Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж, үнэлдэг. |
| Сурагч зохиолын хэл найруулга, хэлний хэрэглээнээс суралцдаг болсон байна.                      | Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ, тайлбар, нэр томьёог хэрэглэдэг.        |
|                                                                                                 | Зохиолын хэл найруулгаас суралцан, дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиодог.                                   |
|                                                                                                 | Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэдэг.                              |

## Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                                               | Гүйцэтгэлийн түвшин                                                                                     |                                                                                                                                                                     |                                                                                                                                                                                                                   |                                                                                                                                                                                                                                                                                      |
|----------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                                              | I                                                                                                       | II                                                                                                                                                                  | III                                                                                                                                                                                                               | IV                                                                                                                                                                                                                                                                                   |
| Сурагч зохиолын зохиомж ба өгүүлэгдэхүүн бүтэц нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэдэг. | Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллын уялдааг холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг дүгнэдэг. | Зохиолын өгүүлэгдэхүүний уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлохоос гадна зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/-ийг олж дүгнэдэг. | Зохиолын өгүүлэгдэхүүн болон зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал, харилцан яриа, дотоод яриа гэх мэт/ -ийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/ хийж дүгнэдэг.              | Зохиолын өгүүлэгдэхүүн болон зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/, хүүрнэлийн дуу хоолойн үүргийг утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/ хийж дүгнэдэг.                                                                                                   |
| Сурагч дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд нөлөөлж буйг тайлбарладаг.                | Дүрийн нийтлэг зан төрх утга санаанд нөлөөлж буйг тайлбарладаг.                                         | Дүрийн нийтлэг зан төрх, хувь хүний өвөрмөц онцлог шинж утга санаанд нөлөөлж буйг тайлбарладаг.                                                                     | Дүрийн нийтлэг зан төрх, хувь хүний өвөрмөц онцлог шинж, зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдэл нь зохиолын сэдэв, утга санаанд нөлөөлснийг; зохиолч дүр бүтээснээрээ уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг тайлбарладаг. | Дүрийн нийтлэг зан төрх, хувь хүний өвөрмөц онцлог шинж, зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдэл нь; хэв шинжит дүрээрээ дамжуулж, нийгэмд, хувь хүнд /үлгэрлэх, жигших/ юуг хэлэхийг хүссэн хийгээд утга санаанд нөлөөлж буйг жишээгээр тайлбарладаг.                                   |
| Сурагч зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг.                | Зохиолд үзүүлж буй орон, цаг, гадаад орчин дүртэй холбогдож нөлөөлж буйг задлан шинжилдэг.              | Гадаад буюу орчин, нөхцөл байдал нь, мөн дотоод орчин буюу тэдний харилцаа, уур амьсгал нь дүрийг тодруулахад нөлөөлж буйг задлан шинжилдэг.                        | Зохиолын гадаад орчин, нөхцөл байдал/орон цаг/, дотоод орчин цаг уур амьсгал нь дүрийн сэтгэл зүй, бодол санаа, үйлдэл, үзэл бодолд нөлөөлж буйг задлан шинжилдэг.                                                | Зохиолын гадаад орчин/ түүхэн нөхцөл байдал/, орон цагийн дүрслэл/ дүрслэл эд юмс багтсан эсэх/, дотоод орчин / байгаль, цаг уур, сэтгэл зүйн өнгө аяс, харилцаа, зөрчил/ уур амьсгал дүрийн сэтгэл зүй, бодол санаа, үйлдэл, үзэл бодлыг тодруулахад нөлөөлж буйг задлан шинжилдэг. |

|                                                                                                                         |                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                        |                                                                                                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                                                                                                         |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.                                        | Зохиолд хүний амьдрал, үзэгдэл юмсын талаар хэрхэн өгүүлсэн, ямар далд санаа бүтээснийг ерөнхий тайлбарладаг.                                                                                             | Зохиолын үндсэн /дэд/ сэдэв, хам сэдвүүд /нийгэм, соёл, түүх, шашин, улс төр, шинжлэх ухаан, намтар/-ийн үгээр “хэлсэн” шууд/ ил/ ба далд утгыг тайлбарладаг.                                                          | Зохиолын хам /нийгэм, соёл, түүх, шашин, улс төр, шинжлэх ухаан, намтар/ сэдэвт ямар далд санааг уран дүрслэл бүхий үгээр бүтээснийг, үзэл бодол, үнэт зүйлсийн талаар “үгээр үл хэлсэн” далд утга санааг тайлан тайлбарладаг.                                            | Зохиолд үзэл суртал, соёлын онцлогийг тусгаж ямар ялгаатай утга санаа бүтээснийг; хам /нийгэм, соёл, түүх, шашин, улс төр, шинжлэх ухаан, намтар/ сэдэвт ямар далд санааг уран дүрслэл бүхий үгээр бүтээснийг; үзэл бодол, үнэт зүйлсийн талаар “үгээр үл хэлсэн” далд утга санааг тайлан тайлбарладаг. |
| Сурагч зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж, үнэлдэг. | Зохиол дахь уран дүрслэл /адилтгал, егөөдөл, бэлгэдэл гэх мэт/ -ийн утгыг тайлж уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэдэг.                                                                                        | Уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн утгыг тайлж, уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэдэг.                                                                                                                         | Уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг; зохиолын найруулгад гүйцэтгэсэн үүргийг үнэлдэг.                                                                                                                                                 | Уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг; зохиолын хэл найруулгад нөлөөлсөн үүрэг; дүрсэлсэн арга барилын онцлогийг үнэлдэг.                                                                                                                                             |
| Сурагч зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ, тайлбар, нэр томьёог хэрэглэдэг.        | Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэхдээ тайлбар, нэр томьёог оновчгүй хэрэглэдэг эсвэл дутуу хандаж бичдэг.                                                                           | Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэхдээ тайлбар, нэр томьёог буруу эсвэл сольж сонгосон, найруулга болон зөв бичгийн дүрмийн хэд хэдэн алдаа гаргаж бичдэг.                                        | Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэхдээ жишээ, тайлбар, нэр томьёог зөв сонгож хэрэглэсэн, найруулгын болон зөв бичгийн дүрмийн цөөн алдаа нь найруулгад нөлөөлөхөөргүй бичдэг.                                                                       | Зохиолын үг сонголт, өгүүлбэр зүйн ур маяг, уран дүрслэлийн ур маяг, бичил дүрслэлийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэхдээ жишээ, тайлбар, нэр томьёог оновчтой хэрэглэж бичихдээ зөв бичгийн болон найруулгын алдаагүй бичдэг.                                                                            |
| Сурагч зохиолын хэл найруулгаас суралцан, дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиодог.                                   | Эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн уялдаа холбоо алдагдсан эсвэл дүрийн зорилго дутуу; үйл явдлын зөрчил/ бэрхшээл/-бага; уран дүрслэлтэй ч найруулгын алдаа их уншигчдад хэлэх санаа нь ойлгомжгүй зохиодог. | Эхлэл, гол, төгсгөл хэсэгтэй, дүрийнхээ зорилго, дүр байдал, зан чанар, баатруудад тохиолдсон явдал, үйл явдлын зөрчил /бэрхшээл/-тэй, уран дүрслэлтэй ч найруулгын алдаа их уншигчдад хэлэх санаа нь бүрхэг зохиодог. | Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд нь уялдаатай; орон цагийн зөв тохироотой, дүрийнхээ зорилго, дүр байдал, зан чанар, баатруудад тохиолдсон явдал, үйл явдлын зөрчил/ бэрхшээл/-тэй, уран дүрслэлтэй ч /найруулгын алдаа бага/ уншигчдад юу хэлэх санаа нь ойлгомжтой зохиодог. | Эхлэл, гол, төгсгөл хэсгүүд нь нягт холбоотой; орон цагийн зөв тохироотой, дүрийнхээ зорилго, дүр байдал, зан чанар, баатруудад тохиолдсон явдал, үйл явдлын зөрчил/бэрхшээл/-тэй, уран дүрслэл, уран санаатай, уншигчдад юу хэлэх санаа нь ойлгомжтой зохиодог.                                        |

|                                                                                            |                                                                                                                                                                                                                                                       |                                                                                                                                                                                                                                                                                                  |                                                                                                                                                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                                                                                                                                                                            |
|--------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| Сурагч зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэдэг. | Илтгэлийн сэдэв агуулгатайгаа тохироогүй, зорилгоо бүрэн илэрхийлж чадаагүй /уран дүрслэл, яруу хэрэглүүрийн үүргийг тайлан тайлбарлаж буй жишээ, эшлэл, өвөрмөц содон үг хэллэг хэрэглэснийг онцолж аваагүй, эсвэл оновчгүй/ дүгнэлт дутуу илтгэдэг. | Илтгэлийн сэдэв агуулгатайгаа тохирсон ч зорилгоо зөв тодорхойлоогүй /уран дүрслэл, яруу хэрэглүүрийн үүргийг тайлан тайлбарлаж буй жишээ, эшлэл тохирсон, өвөрмөц содон үг хэллэг хэрэглэснийг онцолж аваагүй, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дурдсан/ дүгнэлт дутагдалтай илтгэдэг. | Илтгэлийн сэдэв агуулгатайгаа бүрэн тохирсон, зорилго тодорхой / уран дүрслэл, яруу хэрэглүүрийн эшлэл жишээ оновчтой, орчин, дүрийг гаргахдаа өвөрмөц содон үгийг онцолж авч үзсэн, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг авч үзсэн/, дүгнэлтэд хийхдээ дутуу хандсан эсвэл, сонирхол татахаар бэлтгээгүй илтгэдэг. | Илтгэлийн сэдэв агуулгатайгаа бүрэн тохирсон, зорилго тодорхой /уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн үүрэг, уншигчдад үзүүлэх нөлөөг тайлан тайлбарлаж буй жишээ, эшлэл оновчтой, орчин, дүрийг илэрхийлсэн өвөрмөц содон үг хэллэгийг ялган онцолж авч үзсэн/, дүгнэлттэй, сонирхолтой байдлаар бэлтгэж уран сайхнаар илтгэдэг. |
|--------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

### 3.2.3. Үнэлгээний нэгж 3. Шүлэглэсэн зохиол

| Суралцахуйн зорилт                                               | Суралцахуйн үр дүн                                           |
|------------------------------------------------------------------|--------------------------------------------------------------|
| 12.1е. Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг задлан шинжлэх. | Сурагч яруу найргийн зохиолыг задлан шинжилдэг болсон байна. |

#### Суралцахуйн үр дүнгийн шалгуур

| Суралцахуйн үр дүн                                           | Шалгуур                                                            |
|--------------------------------------------------------------|--------------------------------------------------------------------|
| Сурагч яруу найргийн зохиолыг задлан шинжилдэг болсон байна. | Сурагч яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг задлан шинжилдэг. |

#### Шалгуур тус бүрийн гүйцэтгэлийн түвшин

| Суралцахуйн үр дүнгийн шалгуур                                     | Гүйцэтгэлийн түвшин                                                       |                                                                                                                                                                                          |                                                                                                                                                                                           |                                                                                                                                                                                                                     |
|--------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|                                                                    | I                                                                         | II                                                                                                                                                                                       | III                                                                                                                                                                                       | IV                                                                                                                                                                                                                  |
| Сурагч яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг задлан шинжилдэг. | Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалын ойлголт буруу, дутуу шинжилдэг. | Яруу найргийн зохиолын агуулга, хэлбэрийг бүтээхэд айзам хэмнэл / үүргийг/-ийг; эгшиг авианы зохицлоос эгшиглэл /эгшиг аялгуу/-ийг; бадаглалын онцлогийн аль нэгийг нь задалж шинжилдэг. | Яруу найргийн зохиолын агуулга, хэлбэрийг бүтээхэд айзам хэмнэл / үүргийг/-ийг; эгшиг авианы зохицлоос эгшиглэл /эгшиг аялгуу/-ийг; бадаглалын онцлог зэргээс хоёрыг нь задалж шинжилдэг. | Яруу найргийн зохиолын агуулга, хэлбэрийг бүтээхэд айзам хэмнэл /үүргийг/-ийг; эгшиг авианы зохицлоос эгшиглэл / эгшиг аялгуу/-ийг; бадаглалын бүтэц-байгууламжийн онцлогийг задалж, үнэлгээ дүгнэлт өгч шинжилдэг. |







**“ЕБС-ийн Монгол хэлний хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуур”-ыг боловсруулсан ажлын хэсэг:**

|                |                                                |
|----------------|------------------------------------------------|
| Ш.Оюунцэцэг    | БМДИ-ийн зөвлөх                                |
| Ц.Март         | 11-р сургуулийн багш, зөвлөх                   |
| М.Болдсайхан   | БҮТ, Шалгалт судалгаа хариуцсан хэлтсийн дарга |
| Д.Энхжаргал    | БҮТ-ийн ахлах мэргэжилтэн, магистр             |
| Т.Отгон-Эрдэнэ | БҮТ-ийн мэргэжилтэн, тэргүүлэх                 |
| О.Батмөнх      | 39-р сургуулийн багш, тэргүүлэх, магистр       |
| Н.Батбаяр      | 33-р сургуулийн багш, тэргүүлэх, магистр       |
| И.Сансартуяа   | “Сант” сургуулийн багш                         |

**Хөндлөнгийн шинжээч:**

|             |                           |
|-------------|---------------------------|
| Ө.Цэндсүрэн | Монгол улсын гавьяат багш |
|-------------|---------------------------|

**Техникийн редактор:**

|                |                                           |
|----------------|-------------------------------------------|
| Т.Отгон-Эрдэнэ | Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн |
|----------------|-------------------------------------------|

**Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:**

|              |                                                 |
|--------------|-------------------------------------------------|
| Э.Сансартуяа | “Хас дизайн пресс” ХХК-ийн дизайнер             |
| Л.Алтансүх   | Боловсролын үнэлгээний төвийн ахлах мэргэжилтэн |





БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ  
**БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

## **БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ**

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо  
Энхтайваны өргөн чөлөө, Арслантай гүүр  
“ОЮУНЫ УНДРАА” группийн байр

---

Утас: 70119498, 70118485  
И-мэйл: [info@eecs.mn](mailto:info@eecs.mn)